

БӨХӨНГИЙН МЭДЭЭ

Бөхөнгийн экологи ба хамгааллын талаар мэдээлэл солилцох 6 хэл дээрх хэвлэл



Зургийг Анна Пурцсана

Хулгайн анчдын гарт амь үрэгдсэн Улдис Кнакисийн дурсгалд (1939 – 1970) зориулав

...Есдүгээр сарын тэр нэгэн гай дагуулсан өглөө Улдис Кнакис жолооч П.Волоховын хамт бөхөн тоолохоор явж байв. Ажиглалтын модон цамхагийн орой руу өгсөж явсан Кнакис талд зогсож буй машиныг олж харлаа. Тэднийг ойртон очихыг хармагцаа хулгайн анчид зугтахаар яаравчиллаа. Хулгайн анчдын машины тэвшийг гэрэлтүүлэхдээ түүн дотор бөхөнгийн эвэр байгааг Кнакис ажиглав. Зугтаахгүй гэж тохиролцсон ёсоор хулгайн анчид буугаа байцаагч руу чиглүүлэн буудав. Кнакис өөрийн сайн найзын мөрөн дээр унахыг л мэдэрсээ. Энэ үхлийн шарх байлаа.



Улдис Кнакис.

Улдис Кнакис харамсалтайгаар амь үрэгдсэний 40 жилийн ой 2010 оны есдүгээр сарын 26-нд тохиож байна. Тэрээр Иркутскийн Хөдөө аж ахуйн хүрээлэнгийн туслах ажилтнаас эхлээд Халимагийн талд судлаачаар ажиллаж байсан бөгөөд тэнд бөхөн хамгаалах анхын мэргэшсэн багийг үүсгэн байгуулжээ. 1960-70-аад оны үед хулгайн анчид машин тэргээр хөөж, нүүдэллэх замд нь буудах зэргээр амьтдыг хэдэн зуу, мянгаар нь хөнөөж байв.

Үргэлжлэл 2-р нүүрэнд.

This edition is funded by:

АГУУЛГА

Шуугиан дэгдээсэн материал

Хулгайн анчдын гарч амь үрэгдсэн Улдис Кнакисын (1939 – 1970) дурсгалд 1

Сүүлийн үеийн мэдээ

Е.Ж.Милнер-Гулланд

Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенци (СМС)-д оролцогч талуудын 2 дахь уулзалтын томоохон амжилт нь бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичиг байв 3

Роберт Женкинс

Хятад улс бөхөнг тогтвортой ашиглах, хамгаалахад анхаарал тавьж байна 4

Антони Дансер

Зэрлэг ан амьтдыг хамгаалах үзэсгэлэн WCN 2010..... 5

Хэвлэлийн мэдээ..... 6

Устюртын газар нутгийг хамгаалах хил дамнасан хэлэлцээр

Казахстаны засгийн газрын бөхөн хамгаалах арга хэмжээнүүд

Хууль бус агнуурын өнөөгийн байдлын тойм

Калмык, Хятадын мэдээнүүд

Өгүүлэл

Алберт Салемгареев, Оркен Шаймуқанбетов, Стефан Зутер,

Сергей Скляренок

Бетпак-далагийн бөхөнд сансрын дохиололтой хүзүүвч зүүсэн хөтөлбөрийн 2009-10 оны үр дүн..... 11

Мэттью Браун, Нэвиндер Сингх

Нөхөрлөлийн менежментийн арга замыг ашиглан бөхөнгийн трофейн агнуур явуулах боломж..... 12

А.В. Проняев

Баруун хойд Каспий орчмын бөхөнгийн популяцийн динамик... 14

Е.А. Быкова, А.В. Есипов

Узбекистаны мониторинг хөтөлбөрийн 2009-2010 оны үр дүн... 16

М.К. Сапанов

Волга-Уралын бүс дэхь бөхөнгийн учир битүүлэг үхлүүд..... 18

Д. Санжмятав

Хамгааллыг төлөвлөх зорилготой “Биосан” программ 19

Фенглиан Ли

Гуанжоуд хийгдсэн бөхөн хамгаалахад чиглэгдсэн асуулгын судалгаа... .. 20

Бөхөнгийн баатрууд 20

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн анхны хүндэт гишүүн

профессор Аманкул Бекенов 21

Төслийн тойм 24

Төслийн шинэ ном

1-р нүүрний үргэлжлэл:

Анчид байцаагчдыг таньсан дороо маш түргэн зугтааж чаддаг байсан учраас хулгайн агнуурын ийм байдалтай тэмцэхэд маш хүнд байв. Хэдэн зуун километр үргэлжлэх усжуулалтын сувагт бөхөн олноороо үхэж байв. Барилгачид амьтдад зориулсан гарц хийх талаар огтхон бодолцоогүй бөгөөд бетонон хашаагаар амьтад гарч чадахгүй байв.

Сонины нүүрэн дээр Кнакис бөхөнг хамгаалах зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авахын тулд хүмүүст хандсан нь амжилттай болсон бөгөөд маш сайн тоног төхөөрөмжөөр хангагдсан, мэргэшсэн байцаагчдын багийг бий болгосон. Усжуулалтын сувагт амьтад гарах байгууламжийг барих талаар тусгайлсан үйл ажиллагаа явагдаж байв. Улдис Кнакис томоохон төлөвлөгөө байсан. Харамсалтай нь тэрээр ердөө 31-хэн настай байхдаа нас баржээ. Мөрдөгчид түүнийг алсан хүнийг олоогүй байна.



Зургийг Юрий Арслоев

Улдис Кнакис зориулсан хөшөөг сэргээж буй нь

Юстинский дүүрэгт, түүний нас барсан газарт хөшөө босгожээ. Иркутскийн хөдөө аж ахуйн хүрээлэнд У.Кнакисийн нэрэмжит залуучуудын бүлэг байгуулагдсан. Энэ жил түүний нас барсаны ойг тэмдэглэхийн тулд Халимагт хамтран ажиллаж байсан хүмүүсийн хөшөөг сэргээн босгох, дурсгалын гантигийг алтдах зэрэг санаачлагыг Бөхөн хамгаалах нийгэмлэг дэмжсэн болно.

Нэмэлт мэдээллийг Ю. Н.Ариловын kalmsaiga@mail.ru хаягаар хандаж авна уу

Сүүлийн үеийн мэдээ

Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенци (CMS)-д оролцогч талуудын 2 дахь уулзалтын томоохон амжилт нь бөхөн хамгаалах харилцан ойлголцлын санамж бичиг байв.

E.J. Milner-Gulland

Лондонгийн эзэн хааны коллеж, Бөхөн хамгаалах нийгэмлэг, e.j.milner-gulland@imperial.ac.uk

Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенцид бөхөн хамгааллын харилцан ойлголцлын санамж бичиг 2006 оны 9-р сараас хүчин төгөлдөр болсон. Анхны уулзалтаар ирэх 5 жилд бөхөнгийн тоо толгойн бууралтыг багасгах, зогсооход чиглэсэн зорилго бүхий эн тэргүүний ажлуудын багтаасан Олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийг (ОУДХАХ) баталсан. Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан талууд, бөхөн судлаачид 2010 оны 9 сарын 7-ноос 10-нд Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо дахин уулзаж, өмнөх ажлын амжилт ололтыг хэлэлцэн, бусад асуудал руу чиглэсэн дараагийн 5 жилд хэрэгжих Олон улсын дунд хугацааны ажлын хөтөлбөрийг шинэчлэн баталсан байна.

Энэ уулзалтын уур амьсгал, ач холбогдол гайхалтай байсан бөгөөд хэлэлцэж буй асуудлуудад гарцыг олж, харилцан зөвшилцөлд хүрсэн билээ. Энэхүү ил тод байдал нь уг зүйлийн хамгааллын статуст ашигтай нөлөө үзүүлэх олон талт, илүү үр дүнтэй үйл ажиллагааг бий болгоно гэдэгт би итгэлтэй байна. Үнэндээ хүмүүс Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн туг дор хэдэн жил тутамд бие биетэйгээ уулзан, нүүр тулан асуудлыг хэлэлцэж, зөвшилцөлд хүрч байгаа нь хамгааллын үр нөлөөг дээшлүүлэх томоохон хүчин зүйл юм.

Эхний 2 өдөр техникийн зөвлөгөөн болсон бөгөөд оролцогчид Бөхөн хамгаалах эвсэл, ОУБХХ-ны Зүйлийг хамгаалах комисс, (IUCN-SSC Antelope Specialist Group), Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийн хамгаалах конвенцийн нарийн бичгийн дарга нарын уулзалтын үр дүнд гарсан баримт бичгүүдийг хэлэлцсэн. Тэдгээр нь бөхөнгийн өнөөгийн байдлын талаарх тойм мэдээ, өмнөх ОУДХАХ-н хэрэгжилтийн үр дүнгийн тайлан, 2011-2015 онд хэрэгжих засвар оруулсан ОУДХАХ зэрэг баримт бичиг байсан. Хуралд оролцогчдын хийж байсан нарийвчилсан, үр ашигтай саналуудын үр дүнд 9-р сарын 9-10 нд болсон харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан талуудын албан ёсны уулзалтаар батлуулах баримт бичгүүд ихээхэн боловсронгуй болсон билээ. Мөн техникийн зөвлөгөөнд оролцогчид ОУДХАХ-ийн янз бүрийн асуудлыг хөндсөн амжилт ололтыг харуулсан илтгэлийг хэлэлцүүлж байлаа.



Талуудын уулзалтыг нээж байгаа нь.



Зургаа: Александр Естанов

Монгол, Бөхөн хамгаалах нийгэмлэг, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа.

Бөхөнгийн мониторинг үйл ажиллагааны нөлөөгөөр 1990-ээд оны эхээр тоо толгой нь буурч байсан таван популяцийн 4-нх нь бууралт 2000 оны эхээр зогсонги байдалд орсоньг нотолж байгаа хэдий ч эргэн хэвийн байдалд оруулахад хөдлөшгүй, бодит асуудлууд байсаар байна. Устюртын популяци байнгын дарамтан дор байсаар байгаа бөгөөд шийдвэртэй арга хэмжээ авахгүй л бол уг популяци устаж үгүй болох бодит аюул тулгарч байна. Оросын популяци мөн л хэцүү байдалтай тулгараад байгаа ба Уралын популяци ихээхэн үхэж хорогдон, хүнд нөхцөлд байна. Гэхдээ олон нийтийн үүрэг, худалдаа, мониторинг, тусгай хамгаалалттай газар нутаг зэрэг ОУДХАХ-т тусгагдсан дийлэнх асуудлууд ихээхэн амжилттай хэрэгжиж байна. Зарим популяциудын асуудлыг үл харгалзан, гэрээнд нэгдсэн талуудын анхны уулзалтаас хойш бөхөн хамгаалал хир зэрэг хол явсаныг илэрхийлсэн хурлын илтгэл баримт бичгүүд нь бүх оролцогчдын бахархах зүйл болж байв.

Мөн хурлын явц бөхөн хамгаалах өөр арга замууд руу чиглэн өрнөж байв. Зөвхөн *tatarica* дэд зүйлийг биш, *Saiga* төрлийг хамгаалахын тулд харилцан ойлголцлын санамж бичгийг өргөжүүлэх ажлыг Монгол улс дангаараа гүйцэтгэж ирсэн бөгөөд цаашид өргөжүүлэх шаардлагатай юм. Бөхөн хамгаалах эвсэл, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг зэрэг сүүлийн жилүүдэд бөхөн хамгаалах талаар идэвхитэй ажиллаж байгаа 2 байгууллага хамтран ажиллахаар гарын үсэг зурлаа. Эдгээр байгууллага нь харилцан ойлголцлын санамж бичгийг хэрэгжүүлэхийн тулд зохицуулгын механизмыг хангах нарийн бичгийг дарга нарын уриалгыг хамтдаа хүлээн авсан юм.

Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийг хамгаалах конвенцийн уулзалтын дараа Бөхөн хамгаалах эвсэл жил бүрийн уулзалтыг зохион байгуулах боломжийг хангахын тулд Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийн захирал Ольга Климановаг БХН-ийн удирдах зөвлөлийн гишүүнээр, профессор А.Бекеновыг хүндэт гишүүнээр сонгосон.

Энэ гишүүнчлэл нь түүний урд удаан хугацаанд бөхөн хамгаалах талаар хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн байлаа (Бөхөнгийн мэдээний сүүлийн өгүүллийг хар).

ЗАНЗХК-ийн уулзалтыг зохион байгуулсан Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар маш сайн ажилласан бөгөөд зөвхөн хурлыг сайн зохион байгуулсан төдийгүй хуралд оролцогчид Монголд найрсаг уур амьсгалыг мэдэрч байв. БОАЖЯ-ны зохион байгуулсан хүндэтгэлийн оройн зоогоос бид Монголын хөдөө нутаг, цэвэр агаарын талаар өргөн мэдлэг олж авсан бөгөөд өвөрмөц хоолойгоор дуулж, бүжиглэж байсан нь хурлын өрөөнд эрчимтэй ажилтай байсан өдөр, шөнөөс биднийг түр амсхийлгэж сайхан байлаа.

Би энэ хуралд оролцоод буцахдаа бүх оролцогчид эх нутагтаа 2006 оноос эхлэн бөхөн хамгаалах талаар бодитой ахиц дэвшил бүхий маш их ажил хийж байгааг мэдэрсэн. Бөхөнгийн хамгаалал нийгэм болон экологийн хувьд өргөн газар нутагт уг зүйлийн гүйцэтгэх үүрэгт хандсан хамтын ажиллагааны шинэ эринд шилжиж байна. Энэ хурал биднийг өмнө байгаа маш том зорилгын төлөө эрч хүчээр цэнэглэлээ.

Редакторын тэмдэглэл: Хурлын бүх материал http://www.cms.int/species/saiga/2ndMtg_Mongolia/2nd_saiga_range_states_meeting.html-д байгаа.

Хятад улс бөхөнг тогтвортой ашиглах, хамгаалахад анхаарал тавьж байна.

Роберт .В. Г. Женкинс

Зүйлийн менежментийн мэргэжилтэн, hank.jenkins@consol.net.au

Бөхөнг тогтвортой ашиглах, хамгаалах олон улсын хурлыг зарласан нь Хятад уг зүйлийг хамгаалахын тулд олон улсын хүчин зүтгэлийг авах эрмэлзэлтэй байгааг харуулж байна.

Шинжианы автономит бүсийн Өрөмчи хотод 2010 оны 9-р сарын 27-29-нд болсон уг хурлыг Зэрлэг амьтан Ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) Хятад дахь менежментийн хэлтэс, Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенци (CMS) болон Зэрлэг амьтан ургамлын ховордсон зүйлүүдийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн нарийн бичгийн дарга нарын газар, Шинжианы ойн хэлтэстэй хамтран зохион байгуулсан юм. Бүс нутгийн бөхөнгийн статусын талаар Казахстан, Монгол, ОХУ, Узбекистанаас ирсэн оролцогчид танилцуулсан. Өрөмчи хотод болсон хурал нь Зэрлэг амьтан ургамлын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах олон улсын конвенцийн харилцан ойлголцлын санамж бичигт оролцогч талуудын 2 дахь уулзалтаар боловсрогдон гарсан 2011-2015 онд хэрэгжих ОУДХАХ дэхь бөхөнг тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах асуудалд төвлөрсөн юм.

Олон улсын хоёр конвенцийн төлөөлөл, засгийн газрын албан тушаалтнууд уг хурлыг нээн үг хэлсэн бөгөөд бөхөнгийн хамгаалалд учирч буй асуудлуудыг олон талаас нь хөндсөн илтгэлүүдээр үргэлжилсэн. Эдгээр үндсэн асуудлын дараа улс тус бүрийн зүйлийн хамгааллын өнөөгийн байдал, менежментийн ялгаатай тал, хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, түүнчлэн бүс нутагт тулгарч буй бэрхшээлтэй асуудлуудыг тусгасан илтгэлүүд хэлэлцэгдсэн.



Зургийг Зане Янг авч

Нэгдсэн зөвлөгөөн.

Харилцан ойлголцлын санамж бичигт оролцогч 5 орон (Казахстан, Монгол, ОХУ, Туркменистан, Узбекистан) бөхөнгийн популяцийг нөхөн сэргээх, түүний хамгаалалд томоохон ахиц дэвшил хийх үйл ажиллагаанд (судалгаа, мониторинг, хулгайн антай тэмцэх багийн тоог нэмэгдүүлэх, орон нутгийн нөхөрлөлийн боловсрол, сургалт, сурталчилгааны хөтөлбөр гэх мэт) чиглэгдсэн 2007-2011 онд хэрэгжих ОУДХАХ-ийг 2006 онд баталсан бөгөөд үүний үр дүнг тодорхойлсон.

Зэрлэг амьтан Ургамлын ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенцийн (CITES) Хятад дахь менежментийн хэлтэс хуулийн хэрэгжилтийг сайжруулах, бөхөнгийн эврийн хууль бус нийлүүлэлтийг илрүүлэх зэрэг Хятадад авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг нарийвчлан боловсруулсан.

Хятадад байгаа бөхөнгийн эврийн нөөцийг албан ёсоор дансалж бүртгэн, савлан коджуулж лацадсан байдаг. Бөхөнгийн эвэр агуулсан уламжлалт эм үйлдвэрлэж буй компанийг олон удаа ашиглагдахгүй тамга тэмдэг бүхий коджуулсан савлагаагаар таньж болно. Зөвхөн таних тэмдэгтэй эмүүд нь засгийн газрын тогтоосон квотын дагуу олон нийтэд худалдаалагддаг байна.

Бөхөнгийн эвэр нь уламжлалт эмийн бүтээгдэхүүний маш чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Хамгийн чухал нь бөхөнгийн эврийн албан ёсны худалдан авагч болох Хятадын уламжлалт эмийн үйлдвэр уг хуралд төлөөлөгчөөр оролцсон явдал юм. Нэмж хэлэхэд уг үйлдвэрийн төлөөлөл бөхөнгийн эврийг эмчилгээний зорилгоор ашигладаг өвчнүүдийг тайлбарлан, бөхөнгийн эвэр агуулсан бүтээгдэхүүний хэмжээг үнэлсэн бөгөөд уламжлалт бус эмчилгээний үр дүнг судалж буй талаар мэдээлсэн. Уламжлалт хятад эмийн Хятадын нийгэмлэг болон



Зургийг Зане Янг авч

Өрөмчийн семинар-хурлыг нээж байгаа нь.

анагаах ухааныхан зэрлэг амьтдыг үр дүнтэй хамгаалан, тогтвортой ашиглахад итгэл хүлээлгэхийг хүссэн хүсэлтээ илэрхийлсэн.

Хурлын 2 дахь өдөр 2 ажлын хэсэг байгуулагдан i) зэрлэг амьтдыг хамгаалахад шаардлагатай менежмент; ii) тогтвортой ашиглалт ба худалдааны зохицуулга зэрэг асуудлыг илүү нарийвчлан хэлэлцсэн. Хоёр ажлын хэсэг маш хэрэгтэй шийдэрүүдийг гарган, нэгдсэн хуралдаан дээр танилцуулсан.

Тианшаны зэрлэг амьтдын цэцэрлэгт хүрээлэн рүү зочилсноор хурлын үйл ажиллагаа өндөрлөсөн бөгөөд олон зэрлэг амьтдын үзмэрийг үзэж сонирхсоны дараа Шинжиан автономит мужийн орлогч дарга ноён Янг Ганг хуралд оролцогчдыг орон нутгийн хоолны гайхалтай зоогонд урьсан.

Өрөмчийн хурал нь Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийн конвенцийн 2011-2015 онд хэрэгжих ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагааг цаашид боловсронгуй болгоход чухал ач холбогдолтой уулзалт болсон. Түүнчлэн анх удаа бөхөнгийн тархац бүхий улсын оролцогчид, Хятадын уламжлалт эмийн үйлдвэрийн төлөөлөл хамтран оролцсон нь илүү үр дүнтэй боллоо. Бүх оролцогчдын үзэл бодлыг өөрчлөн ирээдүйд хамтран ажиллах хүчин чармайлтыг бий болгосон анхны алхмыг хийснээрээ чухал ач холбогдолтой уулзалт болсон.

Уулзалтаас гарсан үр дүн, санал зөвлөмжийн товч хураангуй англи, монгол хэл дээр Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийг хамгаалах конвенцийн http://www.cms.int/news/PRESS/nwPR2010/10_oct/nw_Sai_ga_151010.htm вебсайтад байгаа

Зэрлэг ан амьтдыг хамгаалах үзэсгэлэн WCN 2010

Антони Дансер

anthony.dancer09@imperial.ac.uk

Зэрлэг ан амьтдыг хамгаалах сүлжээ (WCN) жил бүр зохиогддог Зэрлэг ан амьтдыг хамгаалах үзэсгэлэнгийн 7 хоногийг Калифорни мужийн Сан Франциско хотын Бей дүүрэгт 2010 оны 9-р сарын 28-наас 10-р сарын 3-ны хооронд зохион байгууллаа. Сүүлийн 4 жилд бөхөн хамгаалах нийгэмлэг санхүүгийн дэмжлэг үзүүлэх, албан ёсны магадлагаа гаргах, олон улсад гаргах, сүлжээгээр дамжуулах хэлбэрээр чухал ач холбогдол бүхий дэмжлэг үзүүлэн Зэрлэг ан амьтдыг хамгаалах сүлжээтэй хамтран зохион байгуулж байгаа. Жил бүрийн үзэсгэлэнгийн 7 хоногийн үеэр бөхөн хамгаалах нийгэмлэгийн энэ дэмжлэг дээд цэгтэй хүрдэг бөгөөд жил ирэх тусам онцгой, олон талт амин чухал дэмжлэг үзүүлсээр байна.

Үзэсгэлэнгийн долоо хоног нь байгаль орчныг хамгаалагч талуудын цуврал хурал, 2 ивээн тэтгэгчийн үйл ажиллагаа, эцэст нь нийтэд нээлттэй үзэсгэлэн гэсэн 3 үе шаттайгаар явагдсан



Зургийг Мартин Варон

Үзэсгэлэнг сонирхож буй хүмүүс.

Хурлаар зах зээл, санхүүжилтийн арга барил, вебэд суурилсан хамгааллын хэрэгслийг хийх зэрэг олон талт, өргөн хүрээтэй асуудлыг хамран хэлэлцэв. Хамгийн гол нь тэд бүгд бэлэн мөнгөний урсгалыг мэдэгдэхүйц дээшлүүлж, амьдралд шууд хэрэгжих боломжтой жижиг хамгааллын бүлгийн талаарх ойлголтыг авч, эцсийн дүнд байгаль орчныг хамгаалагчдын дэмжлэгтэйгээр тухайн зүйлийг эх нутагт нь хамгаалах талаар хэлэлцэж байв.

Ивээн тэтгэгч хоёр байгууллагын үйл ажиллагаанд Вау дүүргийн сайн сайхны төлөө хандив өгсөөр ирсэн урлаг соёлын одууд оролцлоо. Ховордож буй зүйлийн тархац нутагт ажиллаж буй хүмүүс нүүр нүүрээ тулан уулзсан нь хувийн харилцаа холбоо тогтоох, санхүүгийн дэмжлэгийг илүү их хэрэгтэй газарт илгээх итгэлцлийг бий болгоход тусалсан. Эдгээр үйл явдал нь устах аюулд ороод байгаа зүйлийг хамгаалах талаар олон улсын сонирхлыг татах, эцсийн үр дүнд итгэлтэй байгааг чухалчилсан болно.

Үзэсгэлэнгийн өдрүүдэд уг зүйлийн нөхцөл байдлын талаар өмнө нь мэдэж байгаагүй асуултанд хариулт авах, олон нийтийн мэдлэгийн дээшлүүлэх боломжоор хангагдсан бөгөөд уг долоо хоногийн үйл ажиллагаанд 1000 гаруй хүмүүс идэвхтэй оролцсон.



Зургийг Мартин Варон

Сан Франциско хотын Mission Bay хурлын байранд Елена Быкова бөхөн хамгаалах нийгэмлэгийн илтгэлийг хэлэлцүүлж байгаа нь

Байгаль хамгаалах ажилтнуудын илтгэлийг (Бөхөн хамгаалах нийгэмлэгийн ажилтан Елена Быковынхаар) http://wildlifeconservationnetwork.org/events/expo_videos.html веб сайтнаас үзэж болно. Энэ жилийн үзэсгэлэнд Олон улсын Биологийн төрөл зүйлийн хамгаалах Хүндэт элчин сайд, байгаль хамгааллын гишүүн, жүжигчин Эдвард Нортон оролцсон нь чухал ач холбогдолтой болсон. Ноён Нортон эдгээр бүх үйл ажиллагаанд урам зориг өгч байсан бөгөөд түүнийг Зэрлэг ан амьтдын хамгаалах сүлжээг өргөтгөх, анхаарлаа хандуулж буй зүйлийн хүрээг өсгөхийн тулд ихээхэн зүйл хийхэд огтхон ч эргэлзэх хэрэггүй. Энэ жилийн үзэсгэлэнд оролцсон хүмүүс, ивээн тэтгэгч байгууллагууд, олон хамтран ажиллагчид бөхөн болон бөхөн хамгаалах нийгэмлэгийг ихээхэн сонирхсон нь бас нэг амжилт байлаа. Бүс нутгийн тархцын хүрээнд бөхөнг хамгаалахаар ажиллаж буй бүх хүмүүст баярласан талхсанаа илэрхийлж байв. Цаашдын санхүүжилт болон хандив ихээхэн цугларсан бөгөөд үүний төлөө бид Бөхөн хамгаалах нийгэмлэгт ихээхэн талархаж байна. Эцэст нь бид энэ гайхалтай зүйлийг хамгаалах тэмцэлд үнэлж байршгүй хувь нэмэр оруулсан Зэрлэг ан амьтдыг хамгаалах сүлжээний ажилчид, сайн дурынханд чин сэтгэлийн талрхлаа илэрхийлж байна.



Зургийг Мартин Ворон

Цэцэрлэгт хүрээлэнгийн үдэшлэг. Жижигчин Эдвард Нортон нээлтийн үг хэлж байгаа нь

Хэвлэлийн мэдээ

Узбекистан болон Казахстан улс бөхөн хамгаалах талаар хамтран ажиллахаар тохиролцлоо.

Узбекистаны ерөнхийлөгч Ислам Каримов 2010 оны 8-р сарын 20-нд бөхөнгийн популяцийг тогтвортойгоор өсгөх, нөхөн сэргээх, хамгаалах талаар Казахстаны бүгд найрамдах улстай хэлэлцээр хийн гэрээг баталлаа. Казахстан улсын ерөнхийлөгч Нурсултан Назарбаев Узбекистан улсад айлчлах явцдаа 2010 оны 3 сарын 17-нд уг гэрээнд гарын үсэг зурлаа. Уг гэрээний дагуу хоёр тал үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн өөрийн улс дахь бөхөнг хамгаалах талаар бие биенээс үл шалтгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно. Бөхөнгийн популяцийн мониторинг хийхэд хоёр улс тэгш эрхтэй оролцох бөгөөд мониторинг судалгааны үр дүнг ашиглан хамгааллын арга хэмжээг төлөвлөх болно.

Дэлгэрэнгүйг доорх линкээр холбогдож авна уу:

<http://www.centrasia.ru/newsA.php?st=1283503140>

ба

[http://www.regnum.ru/news/fd-](http://www.regnum.ru/news/fd-abroad/ecology/1321545.html#ixzz0yP6lF8r)

[abroad/ecology/1321545.html#ixzz0yP6lF8r.](http://www.regnum.ru/news/fd-abroad/ecology/1321545.html#ixzz0yP6lF8r)

Устюртын газар нутгийг хамгаалах хил дамнасан хэлэлцээр

Узбекистаны бүгд найрамдах улсын Байгаль хамгаалах үндэсний зөвлөл “Устюртын газар нутгийг хамгаалах санаачлага”-г үнэлэх, төлөвлөх уулзалтыг Узбекистаны нийслэл Ташкент хотноо 2010 оны 8 сарын 9-12-нд зохион байгуулсан. Энэ уулзалтаар Устюрт дахь байгаль хамгааллын үйл ажиллагааны үр дүнг үнэлж шалгалаа. Уулзалтын зорилго нь биологийн төрөл зүйлийг хамгаалах санаачлагыг бүх талуудад танилцуулах, хамтран ажиллах, оролцогч талуудын үүргийг тодруулах байв.



Зургийг Александр Есипов

Ташкетын уулзалт: Паул Ковлес, Pact Inc, байгаль хамгааллын үйл ажиллагааны үр дүнг үнэлэх, хянах уулзалтын явцаас...

Нэмж хэлэхэд оролцогчид бүс нутгийн биологийн төрөл зүйлийг утсгаж буй зүйлс, биологийн олон янз байдалд нөлөөлж буй аюул заналыг үнэлэх арга замыг хэлэлцсэн. Уг уулзалтанд Узбекистаны БНУ-ын байгаль хамгаалах үндэсний зөвлөлийн албан хаагчид, Oliy Majlis-ийн хуулчид, парламентийн гишүүд, олон улсын байгууллага, эрдэмтэн судлаачид, иргэдийн төлөөлөл, сэтгүүлчид оролцлоо. Уг төслийг Байгаль хамгаалах үндэсний зөвлөл, Узбекикийн ШУА-ийн амьтан судлалын хүрээлэн, Шувуу хамгаалах Узбекикийн нийгэмлэг, Амьтан ургамлын аймгийг хамгаалах олон улсын төрийн бус байгууллага (FFI), Pact Inc зэрэг байгууллагууд хамтран хэрэгжүүлэх болно. Уг уулзалтаас амьдралд хэрэгжиж болохоор, үр дүнтэй шийдвэрүүд гарсан.

Дэлгэрэнгүйг: http://www.econews.uz/index.php?option=com_content&view=article&id=703. хаягаар авна уу.



Астанагийн уулзалт. Паул Хотхам (Амьтан ургамлын аймгийг хамгаалах олон улсын байгууллага), Бахытбек Дуйсекеев (Ойн хороо) нар.

Дээрхийн адилаар, Казахстаны БНУ-ын Ой, ангийн хороо Казахстаны нутагт хамаарах Устюртын өндөрлөгийг хамгаалах санаачлагын хөтөлбөрийг хэлэлцэх уулзалтыг Казахстаны Астана хотноо 2010 оны 10 сарын 18-21 нд зохион байгуулсан. Уг уулзалтанд Ой, ангийн хорооны албан хаагчид, Актюбинск, Мангистау бүс нутгийн ой ангийн зөвлөлийн байцаагчид, Охотзоопром улсын аж ахуй, Амьтан ургамлын аймгийн хамгаалах олон улсын байгууллага, Pact Int, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөл оролцлоо. Ой, ангийн хороо, Амьтан ургамлын аймгийг хамгаалах олон улсын байгууллага нь энэ санаачлагын хүрээнд, ялангуяа бөхөн хамгаалах талаар хамтын ажиллагаа батламжилж харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа.

Дэлгэрэнгүйг доорх хаягаар авна уу:

<http://www.oopt.kz/news/detail.php?ID=2436>.

Устюртын газар нутгийг хамгаалах санаачлагыг Их Британы Дарвины санаачлага (UK/DEFRA), Унаган төрхтэй экосистемийг тогтвортой хамгаалах арга зам хөтөлбөр (SCAPES), АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг (USAID) зэрэг байгууллагын хүмүүс боловсруулсан юм.

Казахстаны засгийн газар байгалийн экосистемийг сэргээх, хамгаалах хөтөлбөрийг баталлаа.

Казахстаны БНУ-ын засгийн газар 2010-2014 онд байгалийн экосистемийг нөхөн сэргээх хамгаалах 163,5 тэрбум тэнгэгийн өртөгтэй хөтөлбөрийг баталсан байна. Энэ хөтөлбөр нь ногоон эдийн засгийг хөгжүүлэх, хүрээлэн буй орчин ба эрүүл мэндэд нөлөөлж буй хүний хүчин зүйлийн нөлөөг бууруулах, байгалийн экосистемийг нөхөн сэргээх, хамгаалах, хүрээлэн буй орчны менежментийн чадварыг дээшлүүлэх, боловсронгуй болгох зэрэг үйл ажиллагааны хүрээнд хэрэгжинэ. Засгийн газар уг хөтөлбөрт бөхөнгийн популяцийн хэмжээг 2014 он гэхэд 10% нэмэгдүүлэхээр төлөвлөжээ.

Дэлгэрэнгүй мэдээллийг доорх хаягаар авна уу:

<http://static.zakon.kz/kazakhstan/183661-zhasyl-damu-programma-sokhraneniya-i.html>.

Казахстан бөхөнгийн хууль бус агнуурын зогсоохыг эрхэмлэн үзэж байна.

Казахстаны Хөдөө аж ахуй, усны менежментийн хүрээлэн хэвлэлийн мэдээллийн дагуу бөхөнг хууль бусаар агнаж байгаа үйл ажиллагаанд баримталж буй байр сууриа үргэлжлүүлэн чангатгаж байна. Ой, ангийн хорооны тэргүүн ноён Эрлан Нисанбаев 2010 оны 11 сарын 22 нд болсон бөхөн хамгаалах нийтлэг арга замыг бий болгоход чиглэсэн албан газар хоорондын уулзалтан дээр энэ байр сууриа илэрхийлсэн. Хэдийгээр өмнөх хуульд эрхийг нь хураах, торгууль ноогдуулах талаар хөндсөн бүлэг байгаа боловч Эрүүгийн хууль хатуу шийтгэл ноогдуулах шүүх эрхзүйн тогтолцоонд шилжиж байна. Дээрх торгууль, шийтгэлийг биелүүлснээр хуулийн бүх цоорхой хаагдана гэдэгт Хөдөө аж ахуйн яамны албан тушаалтнууд итгэлтэй байна. Энэ саналыг Дотоод хэргийн яам, Ерөнхий прокурорын газар дэмжсэн байна. Эрүүгийн хуульд оруулсан энэ нэмэлт өөрчлөлтийг Парламентад өргөн мэдүүлээд байна.

Нэмж хэлэхэд Казахстаны Хөдөө аж ахуйн яам бөхөнгийн эвэр худалдаалах зар сурталчилгаа нийтлэхийг хориглох санал гаргажээ. Бөхөнгийн тархац нутгийн хүрээнд 1 кг бөхөнгийн эврийн үнэ 35000-50000 тэнгэ (230-240 ам доллар), Аламатад 200000 тэнгэ (1300 ам доллар) хүрдэг бөгөөд Хятадад 4000 ам доллар хүртэл өсдөг байна. Казахстаны хөдөө аж ахуйн яам бөхөн хууль бусаар агнах эрүүгийн хэргийн хяналтанд илүү анхаарал тавихыг Дотоод хэргийн яамнаас хүссэн байна. Ой ангийн зөвлөл, Охотзоопромтой хамтран чадварлаг анчдын жагсаалтыг гарган Ерөнхий прокурорын газар, Дотоод хэргийн яаманд өгчээ. Зэрлэг амьтдын худалдаанд тавих хяналтыг сайжруулах зорилгоор хилийн хөдөлгөөнт бүлгүүдийг үүсгэн байгуулж байна.

Дэлгэрэнгүйг:

<http://www.centrasia.ru/newsA.php?st=1290498300>,

<http://www.kazpravda.kz/c/1283464537> болон

http://tengrinews.kz/kazakhstan_news/91049 хаягаар авна уу.

Бөхөн Казахстанд хуулийн өөрчлөлтийг бий болгож байна.

Казахстаны Хөдөө аж ахуйн яамны Ой, ангийн хорооны тушаалаар бөхөнгийн эвэр болон бусад хэсгийг худалдах, худалдаж авах, хадгалах, цуглуулах, бөхөн агнахыг хориглосон үйл ажиллагаа 2020 он хүртэл үргэлжилнэ. Нэмж хэлэхэд Казахстаны Хөдөө аж ахуйн яамны дэд сайд ноён Марат Оразаев 2010 оны 10 сарын 23-нд хийсэн мэдээлэлдээ бөхөн агнасан хүнийг 3 жил хорих ялаар шийтгэх тухай санал дэвшүүлсэн байна. Тэрээр ТХГН, амьтны аймаг, ойн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах төслийг илтгэлдээ албан ёсоор дурдсан байна. Өнөөг хүртэл зөвхөн Казахстаны улаан номонд орсон ховор амьтдыг агнасан хүн л хоригдож байсан юм. Энэ өөрчлөлтийг хийснээр бөхөн зэрэг ховор амьтан ургамал олзворлосон хүмүүст ижил шийтгэл ноогдуулах болно.

Дэлгэрэнгүйг:

<http://www.kt.kz/?lang=rus&uin=1133168926&chapter=1153528209>. вэбээр авна уу

Бөхөнгийн дархан цаазат газар Баруун Казахстанд байгуулагдана.

Хэвлэлийн мэдээгээр “Бокейорда-Зайяк” нэртэй дархан газар 2013 он гэхэд Уралын бөхөнгийн популяцийн тархац нутагт байгуулагдах бөгөөд энд 2010 онд пастеролецца өвчин гарсан нутаг хамрагдаж байна (Бөхөнгийн мэдээ №11-ээс хар). *Дэлгэрэнгүйг*
http://www.express-k.kz/show_article.php?art_id=46894.
хаягаар авна уу.

Халимагт бөхөнгийн тоо буурсаар байна.

Халимагийн БНУ-ын байгалийн нөөцийн яам, “Центроохотконтрол” улсын агентлагийн мэргэжилтэнүүдийн мэдээлснээр бөхөнгийн популяцийн тоо сүүлийн арван жилд 10 дахин багасаж 10000 гаруй бодгаль үлдсэн бөгөөд үргэлжлэн буурсаар байна. ОХУ-ын Экологи, байгалийн нөөцийн яамны сайд, Халимагийн БНУ-ын тэргүүн Алексей Орлов нарын хооронд 2010 оны 12 сарын 22 нд болсон ажлын уулзалтаар ОХУ-ын байгалийн нөөцийн яам Черные Земли улсын биосферийн дархан газрын хамгааллын үйл ажиллагааг дээшлүүлэхтэй холбоотой бүс нутгийн засаг захиргааны саналыг хүлээн авсан бөгөөд бөхөн хамгаалахад чиглэсэн цогц үйл ажиллагааг хийхээ мэдэгдсэн байна.

Дэлгэрэнгүйг
<http://eco.rian.ru/danger/20101222/312103262.html>.
хаягаар авна уу.

Shell Халимагийн бөхөн хамгаалах хөтөлбөрийг дэмжиж байна.

Орос дахь гадааддын томоохон хөрөнгө оруулагч Royal Dutch Shell plc (Shell), Халимагийн БНУ-ын засгийн газар нар Халимагийн бөхөнгийн популяцийг сэргээх, хамгаалахад чиглэсэн үйл ажиллагааг дэмжих гэрээнд 2010 оны 8 сарын 26-нд гарын үсэг зурлаа. Шелл энэ зүйлийг хамгаалахад 3 сая рубль (100,000 ам доллар) зарцуулах болно. Энэ хөтөлбөрт Халимагийн бөхөнгийн популяцийн судалгаа, бөхөнгийн шилжилт хөдөлгөөний хэв маягийг судлах, амьдрах орчныг хамгаалах, хулгайн анг хянах, орон нутгийн оршин суугчдын мэдлэгийг нэмэгдүүлэх зэрэг үйл ажиллагаанууд орсон байна.



Халимагийн ерөнхий сайд ноён Олег Кичиков (зүүн гар талынх), Royal Dutch Shell plc-н Орос Каспийн бүс нутгийг хариуцсан гүйцэтгэх захирал Чарльз Ватсон нар бөхөн хамгаалах гэрээнд гарын үсэг зурлаа.

Халимагийн Байгалийн нөөц, Хүрээлэн буй орчны хамгаалал ба Хөгжлийн яам нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хариуцан гүйцэтгэх болно. Энэ гэрээний үр дүнд 4 хүний бүрэлдхүүнтэй бөхөн хамгаалах хэлтсийг үүсгэн байгуулсан бөгөөд цаашид шаардлагатай тоног төхөөрөмж, унаа тэргийг худалдан авахаар төлөвлөж байна. Хөтөлбөрийг хянах ажлыг Орос дахь Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр хийх болно.

Дэлгэрэнгүй мэдээллийг :
<http://www.elista.org/elista/shell-podderzhit-programmu-pohraneniyu-ischezayuschey-populyatsii-saygaka-v-kalmykii-3.html>.
хаягаар үзнэ үү.

Бөхөнд зориулсан шинэ календар Халимагт хэвлэгдлээ.



“Бидний амьд өв-бөхөнг хайрла” гарчигтай календарийг 2010 оны 12 сарын 31-нд Халимагийн бөхөнгийн жилийг хаасаныг тохиолдуулан гаргасан байна. Энэ хэвлэлийг Зэрлэг амьтдыг хамгаалах төв Мегафон компанитай хамтран бэлтгэсэн байна. Энэ хэвлэлийн зорилго нь бөхөн хамгаалах талаар олон нийтийн мэдлэгийг нэмэгдүүлэх юм. Календарийн сар бүрт яг тэр үед нь авсан бөхөнгийн зураг, Халимагийн бөхөнг хамгаалахаар ажиллаж буй хэн нэгний урмын үгтэй захиа байна. Орон нутгийн алдартнууд, олон улсын хамгааллын байгууллагын төлөөлөл эхэнд нь байх агаад бөхөн хамгаалалд оруулж буй тэдний хувь нэмрийг тодорхой бичжээ.

Дэлгэрэнгүйг Ю.Н.Ариловын kalmisaiga@mail.ru.
хаягаар хандаж авна уу.

Хиажоугийн 3 дахь урлагийн наадмын гол дүр болсон бөхөн

Хятадын Гуанжоу хотноо 2010 оны 10 сард болсон Хиажоугийн 3 дахь урлагийн наадамд 2000 гаруй бүжигчид, мэргэжлийнхэн, оюутнууд оролцсон бөгөөд 50000 жуулчид үзэж сонирхон, 10 гаруй мэдээллийн байгууллага ажиллажээ. Хиажоугийн урлагийн наадмыг зохион байгуулах хороо, Файн Арт Гуанжоугийн академийн амьтан хамгаалах нийгэмлэг, Диансуйфенг загварын студи зэрэг газрууд Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр ховордож буй зэрлэг амьтдыг хамгаалахад чиглэсэн өвөрмөц үзэсгэлэнг зохион байгуулсан.

Зургийг Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг



Наадмын зарлалын үндсэн самбар

Уг үзэсгэлэнд байгаа амьтдын хууль бус агнуур хориотой болохыг жуулчдад хүчтэйгээр харуулахыг зорьсон график болон диаграммыг уран сайхны аргаар дүрсэлсэн онцгой байдал нь үзэгчдэд сайхан сэтгэгдэл төрүүлж байв. Бөхөн хамгаалалтай холбоотой видео, зураг, Хятад дахь бөхөнг устгахад нөлөөлж байгаа бөхөнгийн эврийн хэт их ашиглалт, жолоодлогогүй хэрэгцээ шаардлага, хөрш зэргэлдээ бусад орны бөхөнгийн популяцид заналхийлж байгаа аюулыг харуулсан иргэдийн оролцсон үйл ажиллагаа зэргээр бөхөн уг үзэсгэлэнгийн гол дүр болсон.

Гуанжоу дахь хууль бус худалдаа нь удаан хугацаанд Хятадын төдийгүй дэлхий дахины биологийн төрөл зүйлд нөлөөлөх томоохон аюулын нэг байсаар байна. Гуанжоугийн орон нутгийн зах дээр бөхөнгийн эвэр зэрэг хууль бусаар хил давуудан орж ирсэн зэрлэг амьтад, тэдгээрийн бүтээгдэхүүн хоол хүнс, тэжээвэр амьтан, гоёл чимэглэл, эмчилгээний зорилгоор худалдаалагддаг.

Дэлгэрэнгүй мэдээллийг Хятад дахь зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг, Фенглиан Ли-тэй fli@wcs.org холбогдож авна уу.

Зургийг Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг



Дэлхийн байгаль хамгаалах холбооны Улаан дансанд орсон зүйлүүд.

Бөхөнгийн мэдээ

Хятадын Гансу мужийн ховор амьтдыг судлах төвд 24 бөхөнгийн янзага өсөн торниж байна.



Зургийг Gansu EARC

Гансу мужийн ховор амьтдыг судлах төвд байгаа янзагагай бөхөнгийн сүрэг.

Тэнгэр уулын өмнө үзүүрт 1987 онд Гансу мужийн ховор амьтдыг судлах төв байгуулагдах үед уг төвийн анхны ховор амьтан болох бөхөн 21 толгой байсан. Амьтдыг чөлөөтэй идээшлэхэд зориулан 1993 онд хашааг томсгон 30 га-д хүргэсэн байна. Зориудын нөхцөлд буй бөхөнгийн популяци сүүлийн 20 жилийн турш хэлбэлзэлтэй байсан бөгөөд 1997 онд 33 толгой хүрсэн бол 2000 онд 9 болон буурчээ. Сүүлийн жилүүдэд нөхцөл байдал харьцангуй сайжирсан бөгөөд 2009 онд 22 янзага, 2010 онд 24 янзага төрж, популяцийн нийт хэмжээ 80 толгой болж эр эмийн харьцаа 1:1 байна. Хятадын засгийн газар эцсийн дүнд уг зүйлийг түүхэн тархац нутгийн нэгээхэн хэсэгт сэргээн нутагшуулна гэдэгт итгэлтэй байна. Дээрх эх сүргийн цөөн амьтдыг нөхөн сэргээхийн тулд үржүүлгийн төв өөр улс орноос шинэ амьтан авчирч сүрэгт нийлүүлэхийг хүсэж байгаа бөгөөд үүнийг хийхийн тулд хамтран ажиллах байгууллагыг хайж байна.

Дэлгэрэнгүйг Gansu EARC, jianggeapple@126.com болон Айли Канг, akang@wcs.org хаягаар хандаж авна уу.

Хууль бус худалдаа, хулгайн ангийн тохиолдол

Уралын популяци

2010 оны 8 сар

Баруун Казахстаны Акзарын талаас хууль бус ан хийж байгаад баригдсан 4 хулгайн анчин 12 бөхөнгийн эвэр аван 2 мотоциклоор байгаль хамгааллын байцаагч, мал эмнэлгийн цагдаагаас зугтахыг оролдсон байна.

Дэлгэрэнгүйг <http://www.kazpravda.kz/c/1282863423> авна уу

2010 оны 11 сар

Баруун Казахстаны Азхибай тосгоноос 40 км зайд эврийг нь авсан, сумны шархтай 27 бөхөн үхсэн байхыг олсон байна. Дэлгэрэнгүйг:

<http://kt.kz/?lang=rus&uin=1138536468&chapter=1153527210> авна уу.

Устюртын популяци

2010 оны 8 сар

Казахстаны Актюбинк аймгийн Шалкарский дүүрэгт Охотзоопромын байцаагч 2010 оны 8 сарын 26 нд анчинг хэргийн газраас зугтах үед нь буудаж алсан байна. Охотзоопромын албан хаагч эргүүл хийж яваад талд явж байсан мотоцикл унасан хүмүүсийг харжээ. Тэр зогсох шаардлагыг үл харгалзан спорт буугаар тэднийг чиглүүлэн гал нээх зуураа зугтахыг завдсан байна. Үүний хариуд байцаагч тэдний мотоциклыг чиглүүлэн AKS-74 буугаар сануулга өгөх зорилгоор гал нээхэд санамсаргүй байдлаар мотоциклч суманд оногдож газар дээрээ нас баржээ. Үхсэн мотоциклчийн ойролцоогоос буу, бөхөнгийн эвэртэй уут олдсон байна. Мөрдөн байцаалтын явцад байцаагчийн үйл ажиллагааг зөвтгөсөн байна. Дэлгэрэнгүйг <http://www.lenta.ru/news/2010/08/26/shot/> хаягаар авна уу.

2010 оны 11 сар

Актюбинк аймгийн Байганинский дүүрэгт Охотзоопромын байцаагч Мангистау дүүргийн Опорний тосгоны 2 оршин суугч хууль бусаар бөхөн агнасныг илрүүлсэн. Байцаалтын явцад 20 эм, 9 залуу, 1 эр бөхөн алсан болохыг тогтоожээ. Дэлгэрэнгүйг <http://inform.kz/rus/article/2326892>. хаягаар авна уу.

Бетнакдалагийн популяци

2010 оны 6 сар

Костанай аймгийн Зангелдинский дүүрэгт бөхөн агнасан хоёр хүнийг саатуулсан. 35-44 насны хоёр сэжигтнээс буу, бөхөнгийн хос эврийг хураан авсан байна. Эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Дэлгэрэнгүйг <http://kt.kz/?lang=rus&uin=1133168020&chapter=1153522089>. хаягаар авна уу.

2010 оны 10 сар

Иргизский дүүргийн дотоод хэргийн хэлтэс, Охотзоопромын ажилтнууд 2010 оны 10 сарын 28 ний Пүрэв гаригт Зайсанбайск дүүргийн Атанбасын ойролцоо машин зогсоон шалгасан. Уг машин Иргизско-Торгайский байгалийн нөөц газрын эзэмшлийнх байсан бөгөөд дотроо жолооч, хоёр зорчигчийн хамт явж байсан. Машин дотор шалгалт хийхэд бөхөнгийн араг ясны хэсэг, 12 инчийн гол төмөртэй бүртгэлгүй шувууны буу олон. Эрүүгийн хэрэг үүсгэн мөрдөн байцаалт явагдаж байна. Дэлгэрэнгүйг <http://vesti.kz/society/67674>. хаягаар авна уу.

2010 оны 11 сар

Бөхөн хууль бусаар агнаж байгаад 2010 оны 8 сард саатуулагдсан Збан тосгоны хоёр иргэний шүүх хурал 2010 оны 11 сарын 24 –нд Костанай аймгийн Зангелдинск дүүрэгт болсон. Шүүх хулгайн анчин тус бүрийг 700000 тэнгэгээр торгож, нөхөн төлбөрт 282000 тэнгэг авахаар шийдвэрлэсэн. Уг шүүх хурал Казахстаны дотоод хэргийн яамны гүйцэтгэсэн “Хулгайн анчид” нууц нэртэй ажиллагааны сүүлийн шат байв. Энэ ажиллагаагаар галт зэвсэг хэрэглэсэн 3000 илүү зөрчил илрүүлэн 5.5 сая тэнгэгийн торгууль ноогдуулсан байна.

Дэлгэрэнгүйг http://www.express-k.kz/show_article.php?art_id=46051. хаягаар авна уу.

Охотзоопромын байгаль хамгаалагчид 2010 оны 11 сарын 26-нд Тоёота Ланд Круйзер маркийн машинтай явж байсан Кизилордын 3 хүнийг саатуулсан. Караганда аймгийн Акшалад бөхөн өвөлждөг газраас хойш 30 км зайд зогсоосон уг машинаас буудуулсан 11 бөхөн олсон байна.

Мөн өдөр Кизилордын Охотзоопромын байцаагчид машиндаа 24 бөхөнгийн эвэр, 7 зэрлэг гахай, 2 буу авч явсан ОХУ-ын 2 иргэнийг саатуулсан. Тэд Караганда аймгийн Богдокийн ойролцоо сатуулагдсан. Эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж байна. Дэлгэрэнгүй мэдээллийг Свобода Слова сонины 2010 орны 12 сарын 2 ний дугаараас хар.

Баруун хойд Каспий орчмын популяци

2010 оны 7 сар

Черноземелскийн гэрээт албан хаагчид бөхөн хууль бусаар агнасан Артезиан тосгоны иргэн 27 настай залууг саатуулсан юм. Гурван бөхөн, 6 эвэр, бүртгэлгүй буу, хөрөө, хутга зэргийг хэргийн газраас хураасан байна. Энэ үйлдлийг Ерөнхий прокурорын газарт шилжүүлсэн. Дэлгэрэнгүйг http://kalmykia-online.ru/index.php?option=com_content&task=view&id=1340&Itemid=30. хаягаар авна уу.

2010 оны 11 сар

Нарн-Худукскийн бүсийн гэрээт албан хаагч Валерий Мукабенов нутгийн оршин суугч Лузин Сангаджиев, Адам Калидов нарын бөхөн хууль бусаар агнасан хэргийг 2010 оны 11 сарын 1 нд илрүүлсэн. Хулгайн анчид 2010 оны 3 сарын 11 нд 19 бөхөн буудсан байна (Бөхөнгийн мэдээ 11). Байгаль орчинд учруулсан хохирлын төлөө 484500 рублиэр торгосон бөгөөд шийтгэлийг түр зуур хойшлуулан зэмлэн буруушаажээ. Дэлгэрэнгүйг <http://eco.rian.ru/danger/20101102/291706624.html>. хаягаар авна уу.



Зургийг Kazakhstan Today

ӨГҮҮЛЭЛ

Бетпак-далагийн сансрын дохиололтой хүзүүвч хөтөлбөрийн 2009-10 оны үр дүн

Алберт Салемгареев, Оркен Шаймуканбетов, Стефан Зутер, Сергей Складенко

Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг, albert.salemgareev@acbk.kz

Алтын Далаг хамгаалах санаачлага (ADCI), Казахстаны Биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг хамтран 2009 оны намраас эхлэн Бетпак-Далагийн популяцид бөхөн барьж, хүзүүвчилж байна. Энэ хөтөлбөрийн зорилго нь сансрын дохиолол бүхий хүзүүвч ашиглан бөхөнгийн өвлийн байршил, төллөх газар, нүүдлийн замын талаар үнэн зөв мэдээлэл цуглуулах, хулгайн ангийн эсрэг хийгдэж байгаа ажлын үр нөлөөг ихэсгэх юм.

2009 оны 10 сард 20 бөхөн хүзүүвчилсэний 13 нь одоог хүртэл мэдээлэл өгсөөр байна. Хаягдсан 7 хүзүүвчний 5-ийг хээрээс олж, дахин зүүхээр бэлтгэж байна. Эдгээр хүзүүвчнүүд болон шинээр худалдаж авсан 20 хүзүүвчийг 2010 оны намар Бетпак-далагийн популяцийн эм бөхөнд зүүсэн.

Бөхөнг барихдаа бид өнгөрсөн жилийн хээрийн судалгааны үед боловсруулсан “хөдөлгөөнт торны арга” нэртэй аргыг ашигласан.

Хэдийгээр энэ нь баригдаж буй амьтад 100% эрүүл байх баталгаа өгч чадахгүй ч өнгөрсөн 2 жилд хуримтлуулсан бидний туршлага нь хөдөлгөөнт торны арга нь бөхөн гэмтэж бэртэх, хэт халах эрсдэлийг эрс багасгадаг болохыг гэрчилж байна. Энэ аргаар бөхөн барихын тулд мотоцикл ба машинаар тор руу шахаж оруулна (25-35 м урт, 2,5-3 м өндөртэй). Хөөх хугацаа нь агаарын температур, газрын гадаргуу, барих гэж байгаа амьтнаас хамаарч 4,5-5 минут байдаг. Барьсаны дараа хамгийн ихдээ 4 минутын дотор бүх зүйлийг хийх ёстой. Баригдсан амьтдыг бүх амьтдыг хэмжиж, ДНХ-ийн шинжилгээ хийх зорилгоор цусны дээж авахаас гадна үс, баас, эктопаразитын дээж цуглуулдаг.



Бетпак-далад бөхөн хүзүүвчилж байгаа нутаг.

Бүх амьтдын булчинд түргэн сэргээх витамин уусмал 3 мл-ыг тарьсны дараа тавина.

Vectronic Aerospace-ийн байршил тодорхойлох системтэй хүзүүвч ашиглаж байна. (<http://www.vectronic-aerospace.com>). Амьтны байршилыг тодорхойлоход GPS-ийг ашиглах бөгөөд Globalstar хиймэл дагуулын систем нь байршлын мэдээллийг хэрэглэгч рүү майл хэлбэрээр дамжуулдаг. Энэ хэрэгсэл нь бага хүч шаардсан, байршил тодорхойлох систем ашиглан тодорхой солбилцлыг өгдөг, мэдээллийг түргэн шуурхай хүлээн авах боломжийг ханган өдөр тутам мэдээ дамжуулдаг, мэдээлэл дамжуулах найдвартай байдал их зэрэгээрээ давуу талтай юм.

Нэг хүзүүвчний жин ойролцоогоор 600 грамм буюу биений жингийн 2-3%-тай тэнцүү байдаг нь бөхөнд зүүхэд тохиромжтой юм. Барьж хүзүүвчилсний дараах хамгийн эмзэг үе болох 1-2 долоо хоногт амьтны эрүүл мэндэд халтай сөрөг нөлөө ажиглагдахгүй байвал удаан хугацаанд нөлөөлөхгүй гэсэн үг юм.

2009-10 оны төслийн хугацаанд нийт хүлээн авсан дохионы 92.4% нь амжилттай байсан бөгөөд судлаачдад өдөр бүр бөхөнгийн байршилыг мөрдөх боломжийг олгож байна. Өнгөрсөн жил зүүсэн хүзүүвч 2 жил гаруй хугацаанд ажиллах болно.



Хүзүүвч зүүсэн бөхөнг тавьж байгаа нь.

Үүний дараа хүзүүвч өөрөө салж унадаг бөгөөд ингэж хаягдсан хүзүүвчний даавуун материал илжирч муудсан байдаг. Баттерейг сольж, зассаны дараа хүзүүвчийг дахин ашиглаж болно.

Бөхөнгийн телеметрийн судалгаа нь шинжлэх ухааны болон хамгаалалд чухал ач холбогдолтой мэдээллийг өгч байна. Жишээлбэл, 2009 оноос хойших хүзүүвчний мэдээлэл нь байгаль хамгаалагчдын хулгайн ангийн эсрэг үйл ажиллагааг дээшлүүлэхэд, 2010 онд хийгдэх агаарын судалгааны трансектийг төлөвлөхөд нааштайгаар нөлөөлсөн, “Алтын дала” улсын БНГ, “Аккум” зэрэг амьтдын менежментийн нутаг дэвсгэрийн дунд бөхөн төллөдөг чухал байршил газар, орооны үеийн томоохон бөөгнөрлийг (ойролцоогоор 25,000) илрүүлсэн. Хүзүүвч нь бидэнд орооны үеийн байршлыг тодорхойлох, өндөр нягтшилтай нутагт байгаа шинээр тусгай хамгаалалтанд авах газар нутгийг тодорхойлох боломж олгож байна.

Энэ хөтөлбөрт Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг Ой, ангийн хороо (Казахстаны БНУ-ын Хөдөө аж ахуйн яам),

Охотзоопром улсын аж ахуй, Франкфуртын амьтан судлалын нийгэмлэг (FZS), Шувуу хамгаалах эзэн хааны нийгэмлэг (RSPB) хамтран ажиллаж байна. Мөн Грегор Луйсодерын сан, Дарвины санаачлага, Даян Дэлхийн байгаль орчныг хамгаалах төв (GEF), Германы Техник Хамтын Ажиллагааны нийгэмлэг, Германы эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн яамны Олон улсын хөгжлийн төв санхүүгийн ихээхэн тусламж үзүүлж байна.

Бетпак-далаа дахь бөхөнд хүзүүвч зүүсний дараа Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийнхэн Устюртын бөхөнгийн популяцийн тархац нутагт Арал тэнгисийн баруун хэсэгт үйл ажиллагаа үргэлжлүүлж байна. Энэ нутагт Тотторигийн их сургууль (Япон), Узбекистаны амьтан судлалын хүрээлэн, Казахстаны амьтан судлалын хүрээлэн, Амьтан, ургамлын аймгийг хамгаалах олон улсын байгууллага, Нэгдсэн үндэстний байгууллагын хөгжлийн хөтөлбөр, Унаган төрхтэй экосистемийг тогтвортой хамгаалах арга зам хөтөлбөр (SCAPES), Устюртын газар нутгийг хамгаалах санаачлага зэрэг байгууллагатай хамтран одоогийн байдлаар 6 бөхөнд хүзүүвч зүүгээд байна.

Нөхөрлөлийн менежментийн арга замыг ашиглан бөхөнгийн трофейн агнуур явуулах боломж

Мэттью Браун, Нэвиндер Сингх

Лондонгийн Эзэн хааны коллеж, matbrowner@googlemail.com

Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлийг хамгаалах конвенцийн ОУДХАХ 2006 онд батлагдсан бөгөөд үүнд бөхөнг трофейн зорилгоор тогтвортойгоор агнахын тулд нөхөрлөлд түшиглэн бөхөнгийн трофей агнуур хийх боломжийг судлахад доорх сонирхолтой зүйл ажиглагдаж байна.

Трофей агнуур нь орон нутгийн нөхөрлөлийн орлогыг нэмэгдүүлэх, уг зүйлийг болон тэдгээрийн амьдрах орчныг хамгаалахад чухал ач холбогдолтой зүйл болох

нь харагдаж байна. Энэ нь цөөнгүй газарт бусад туурайтан амьтан дээр амжилттай хэрэгжиж байгаа. Дан ганц засгийн газрын менежментээр явахаас илүүтэйгээр хамгааллын менежментийн үйл ажиллагаанд орон нутгийн бүлэг нөхөрлөлийг оролцуулан, эх нутгийнхаа биологийн төрөл зүйлийн үнэ цэнийг хүртэх тэдний сонирхлыг тусалж дэмжихэд орон нутгийн иргэд санал нийлж байна.

Зэрлэг амьтдын нөөцийн менежментийн нэг хэсэг болох Нөхөрлөлд суурилсан трофей агнуурын хөтөлбөр (СВТНР) нь уламжлалт бус амьжиргаанаас нэмэлт орлого олох боломжийг орон нутгийн нөхөрлөлүүдэд санал болгож байна.

Хэдийгээр олон асуудал тулгарч болох ч трофей агнуур нь популяцийн бууралтыг бий болгож байгаа гол арга зам биш болохыг харуулж байна. Бөхөн хамгаалах хэрэгсэл болох трофей агнуурын боломжийг судлан үзсэний дараа бөхөнгийн популяцийн бүтэц, сүргийн динамикт трофей агнуурын нөлөөлөх загварыг боловсруулаад байна.



Ооно.

Загварчлалаас гарсан үр дүн нь бие гүйцсэн оононы трофей агнуурын хөтөлбөр нь боломжтой, тогтвортой байж чадах бөгөөд урт хугацаанд цаг уур зэрэг гадаад хүчин зүйл бага нөлөөлөхийг харуулж байна. Уур амьсгалын өөрчлөлтийг харуулсан Засгийн газар хоорондын 2007 оны тайлангаас үзвэл уур амьсгалын өөрчлөлтийн загвар нь бөхөнгийн тархац нутагт зуны хур тунадас буурч, өвлийн хур тунадасны хэмжээ ихэсвэл бөхөнгийн үхэл ихээр нэмэгдэхийг баталсан байдаг.

Нөхөн үржлийн өндөр эрчим, шаргачин эрт бэлэг боловсрох, амьдралын бүтээмж уртсах, тогтмол ихэрлэх зэргийн улмаас популяцийн хэмжээ эрс өсдөг бөхөнгийн чадавхи нь уг зүйл трофейн агнуурт тогтвортой байхыг харуулж байна. Эр эмийн харьцаа алдагдсан, бие гүйцсэн ооно популяцийн нөхөн үржлийн чадавхид нөлөөлөхөөр болсон популяцид трофейн агнуурыг явуулна. Хэрвээ ооно 1,5-аас дээш настай бол насаар ялгахад бэрхшээлтэй бөгөөд ангийн улирлыг бие гүйцсэн ооно үржилд оролцсоны дараа зохион байгуулна.

Бие гүйцсэн ооно 12 хүртэлх шаргачинг хурааж, хээлтүүлэх бөгөөд эр амьтны тоо харьцангуй бага байх нь популяцийн үр төлөрхөг байдал, шаргачны нөхөн үржилд нөлөөлнө. Үржлийн насны ооныг хэт олноор устгаснаар популяцид үлдсэн залуу настай амьтад давамгайлж эхлэх ба үүний дутагдалтай тал нь залуу ооно үржилд илүү идэвхтэй оролцон ихээхэн турдаг бөгөөд өвлийн улиралд үхэж хорогдох нь нэмэгддэг байна. Нэгэн зүйл гөрөөсний тархац нутаг, үржлийн үеийн зан төрхөд саад уучруулсан эрчимтэй трофейн агнуурыг өмнө нь харуулж байсанчлан энэ нь хээл тээх хугацааг уртасгаж, төлийн үхэл хорогдлыг нэмэгдүүлдэг. Хожимдож төрсөн янзага өвөл болоход биеийн жин багатай байх агаад хатуу ширүүн өвөл амьд үлдэлт бага байдаг.

Нөхөрлөлд суурилсан трофейн агнуурыг хөгжүүлэхэд саад учруулж буй үндсэн хүчин зүйлийн нэг нь хууль бус агнуур ихтэй явдал юм. Үүнийг шийдэхийн тулд хуулиар хорьсон үйл ажиллагаа явагдахгүй ёстой ба орон нутгийн иргэд хулгайн ангаас урьдчилан сэргийлэх ажилд идэвхтэй оролцдог байх ёстой. Энэ арга хэмжээнд оролцсон хөдөөний хүмүүсийг санхүүгээр урамшуулдаг байх ёстой.

Бөхөн байнга агнадаг анчдын дунд 2005 онд (Кухл, 2007) явуулсан судалгаагаар хууль бус ангаас олж байгаа мөнгөний дийлэнх хэсгийг бөхөнгийн махыг худалдаж олдог бөгөөд харин багахан хэсгийг эврийг зарснаар олдог болох нь тогтоогджээ. Тэд агнасан амьтан тус бүрээс 1107 ам доллар (2005 оны үнээр) олдог бөгөөд ойролцоогоор 50-60 бөхөн агнадгийн 15-24 нь бие гүйцсэн эр бодгаль байдаг байна. Трофейн агнуураас олох ашиг тусыг орон нутгийн бөхөн агнадаг хүмүүсийн анхаарлыг татаж байгаа эдгээр орлоготой жишиж үзэх хэрэгтэй.

Төв Ази бол трофей агнуурын гол газар юм. Энэ бүс нутагт олон зүйлийг агнадаг ба олон тур операторууд агнуурын багц үйлчилгээг санал болгодог байна. Хууль бусаар агнасан бөхөнгийн үнэтэй харьцуулбал нэг амьтанд тутамд 250-850 ам долларын зөрүү гарч байна. Трофей агнуурын үнэд 10500-16800 ам доллар төлөх анчдын багт 15-25 эр бөхөн агнуулах нь 50-60 холимог хүйсний бөхөнг агнаж, мах, эврийг худалдсанаас олох 3750-6000 ам доллараас хавьгүй хялбар юм.

Иймээс нөхөрлөлийн менежментийг хэрэгжүүлж буй бүлэг нь бүгдэд хүлээн зөвшөөрөгдсөн чадварлаг удирдлагатай байх бөгөөд тэр нь нөхөрлөлийн гишүүдийг хооронд нь холбож, тоног төхөөрөмж, нөөц, жуулчдыг татах зэрэг менежментэд дэмжлэг үзүүлэх чадвартай байх ёстой. Санхүүжилтыг дур мэдэн зарцуулах, тоо толгойн мэдээ, хууль бус/зөвшөөрөлгүй агнуурын мэдээг хуурамчаар үйлдэх, хээл хахууль авах гэх мэт дүрэм зөрчсөн үйлдэл анчдад бүх талаар ил тод байх ёстой. Нөхөрлөлд тулгуурласан трофейн агнуурын хөтөлбөр нь энэ зүйлгүйгээр олон улсын агнуурын байгууллага, хамгааллын агентлагийн итгэлийг алдаж магадгүй бөгөөд ингэснээр нөхөрлөлд хэрэгжиж буй уг хөтөлбөрийн дэмжлэг байхгүй болно.

Бөхөн асар өргөн газар нутагт нүүдэллэн амьдардаг нь трофейн агнуурын улирлын үед бөхөнгийн популяцийн тархац нутаг дахь тодорхой нөхөрлөлүүд ажиллах боломжтой юм. Энэ нь нөхөрлөлд тулгуурласан трофейн агнуурын хөтөлбөрт оролцон ашиг олохыг хүсэж байгаа бүх нөхөрлөлүүдийн тавьж буй асуулт юм. Хэрхэн энэ асуудлыг шийдвэрлэх, трофейн агнуураас ашиг олж чадахгүй байгаа нөхөрлөлүүдэд хэрхэн хууль бус агнуурыг бууруулах, тэдгээрийн амьжиргааг дээшлүүлэх хэрэгжих боломжтой ямар хувилбар байгаа талаар судалгаа хийх шаардлагатай байна.

Баруун хойд Каспий орчмын бөхөнгийн популяцийн динамик

А.В. Проняев

Оросын үндэсний хөдөө аж ахуйн сургууль, vest-ohot@mail.ru

Баруун хойд Каспий орчмын бөхөнгийн популяцийг сонирхсон хэвээр байна. Энэ нь сүүлийн 15 жилийн турш популяцийн хэмжээнд ер бусын өөрчлөлт гарсанаас үүдэлтэй. Популяцийн мониторинг хийсэн 60 жилийн ажлын үр дүнд тоо толгойн өсөлт нь араасаа үргэлж бууралтыг дагуулдаг болохыг тогтоожээ. Энэ явдал 1600 аад оны дунд үед, 1980-аад оны сүүлээр тохиолдсон. Тоо толгойн бас нэгэн хэлбэлзэл 1996 онд бүртгэгдсэн байна. Тоо толгойн бууралт 2000 он хүртэл үргэлжилж, популяцийн хэмжээ 15 дахин буурсан байна. Цаашлаад энэ бууралтыг дагасан тоо толгойн эрс өсөлт уг газарт болоогүй бөгөөд мэргэжилтнүүдийн үзэж байгаагаар 2004 онд хийсэн сүүлийн бүрэн хэмжээний тооллогоор тоо толгой нь нэмэгдээгүй байв. Өнөөгийн байдлаар популяци нь сүйрлийн ирмэгт байгаа нь тун ойлгомжтой юм.


Өнгөрсөн үед ажиглагдсан энэ хэв маяг нь ирээдүйд ч үргэлжлэх болно. Ангийн квотын тоон үзүүлэлтийг тогтоохдоо энэ зарчмыг хэрхэн ашиглаж байсныг үзье. Би энэ тоон үзүүлэлтийн логик зарчмыг хэлэлцүүлээгүй боловч энэ нь популяцийн хэмжээтэй харьцангуй ойр байх ёстойг тэмдэглэж байна. Квот нь популяцийн биологийн онцлог дээр үндэслэн тогтоогддог бөгөөд нэн тэргүүнд популяцийн динамиктай уялдах ёстой. Хэрвээ квот гүйцэхгүй бол популяцийн хэмжээ үнэлэгдсэнээс доогуур байна гэж үзэж болно.

1980 онд бөхөн барихдаа тор хэрэглэдэг жишиг арга байсан бөгөөд (Максимук, 1982), энэ аргын биологийн урьдач нөхцөл маш ашигтай байсан. Тор тавих газар нутгийг сонголт нь тухайн үеийн популяцийн орон зайн тархацын хамааралтай чухал ач холбогдолтой байсан ба ихэвчлэн бөхөн дамжин өнгөрдөг, гол бөөгнөрөлтэй газарт торыг байрлуулдаг байв. Торын байрлуулахад хагас өдрийн хугацааг зарцуулдаг учраас амьтан багатай газар торонд ордоггүй байна. Иймээс зөвхөн маш том хэмжээтэй сүргээс амьтдыг барихаар төлөвлөдөг бөгөөд ганц нэгээрээ болон тархай бутархай сүрэг торонд ордоггүй байжээ. Туршилтаар барих үед 2000 орчим бодгальтай томоохон сүрэг торыг чиглэн явж байсан. Багууд өдөрт дунджаар 478 бодгаль барьж байв (1983 онд өдөрт 82 баг/өдөрт хийгдсэн барилтан дээр үндэслэсэн). Энэ нь 1980-1985 оны үед нэг сар агналт хийхэд 4-5 багийн квот

20000-90000 бодгаль байжээ.

Энэ технологи нь бөхөн барихад маш үр дүнтэй бөгөөд популяцийн элбэгшлийг үнэлэх илүү нарийн арга байв. Үүнд үндэслэн аль болох богино хугацаанд их мөнгө олох хүсэлтэй бүх ангийн аялалуудыг сэргээж байв. Хэдийгээр популяцийн хэмжээ болон биологийн онцлог цаг тутам өөрчлөгдөж байсан ч энэ технологийн үр бүтээмж тогтмол байсан.

Баруун хойд Каспий орчмын тороор агналт хийж байсан түүхийг сөхөн үзэцгээе (диаг. 1). 1986 оноос өмнө бүх квотыг тороор ан хийгчид гүйцээдэг байв. 1986 онд квот нь анх удаа биелээгүй. Энэ байдал 1990, 1996 онд давтагдсан. 1996 онд популяцийн хэмжээ 300000 толгойд хүрч байв.



Диаграмм 1.

1950-2002 оны хоорондох бөхөнгийн популяцийн хэмжээ, мянган толгойгоор. Квот биелээгүй жилүүдийн дээр квотын биелэлтийн хувийг тавьсан.

Логик ёсоор, квот биелэхгүй байсан нь тэнд тороор агнахад тохиромжтой хангалттай тоо бүхий сүрэг байхгүй байсан, популяцийн хэмжээ үнэлэгдсэнээс доогуур байсныг харуулж байна. 1980 онд бөхөнгийн мониторингийг сайжруулах оролдлого хийжээ (Проняев нар., 1988). Арга зүйг нарийвчлан үзэлгүйгээр, бөхөнгийн популяцийн хэмжээ агаарын тооллогоор тогтоосон дүнгээс 50 хүртэл хувиар бага байсан бөгөөд үнэн хэрэгтээ 1996 онд популяцийн хэмжээ хамгийн ихдээ 150000 толгойд хүрч байжээ.

Доод хэмжээг тодорхойлоход хэцүү байсан бөгөөд 60-80000 бөхөн гэж үзэж байв. Агаарын тооллогын алдаан дээр суурилан үүнийг үнэлсэн бөгөөд 1996 оны дараах нөхцөл байдал энд харагдаж байгаа шиг сүйрлийн ирмэгт тулаагүй байв. Хэрвээ бид үнэмлэхүй (1996, 300,000; 1997, 270,000 зэрэг.) тоог биш, харин жилүүдийн хоорондох хандлагыг ашиглан үзвэл бөхөнгийн тоо толгойн байдал дараах байдалтай байна. 1996, 150,000; 1997, 135,000; 1998, 90,000; 1999, 27,500; 2000, 12,500, гэх мэт. Энэ популяцийн үнэлгээ сүүлийн үеийн тооллогын үр дүнтэй маш төстэй байна.

Гэхдээ тоо толгойн энэ шинэчилсэн үнэлгээ нь зөвхөн популяцийн өнөөгийн уналтын асуултанд зарим талаар хариулж байна. Яагаад популяцийн хэмжээ ихээхэн нэмэгддэг нь тодорхой бус үлдэж байна.

Баруун хойд Каспийн бөхөнгийн 2 экологийн хэлбэр байдаг болохыг харуулсан онолыг 1990 онд гаргаж ирсэн (Соколов нар., 1998). Энэ нь уг популяцийн биологийг өөр өнцгөөс харах боломжийг бидэнд өгсөн юм. Розков, Проняев нар (1994) агнуураас шалтгаалан экологийн хэлбэрүүдийн хоорондох зохиомол селекцийн механизмын санааг дэвшүүлсэн.

Популяцийн бууралтын учир шалтгааныг хэлэлцэн, В.Д. Абагуров (2007) Баруун хойд Каспийн бөхөнгийн амьдрах орчны томоохон өөрчлөлтөнд анхаарлаа хандуулсан. Одоогийн ургамлан нөмрөг нь бөхөнд сайн чанартай тэжээл болж чадахгүй байна. Ер бусын экоморфтэй амьтад нь шилжилт хөдөлгөөн багатай, өсөлтийн эрчим сул, нөхөн үржлийн бага эрчимтэй байдгаараа онцлог бөгөөд тэдгээр нь өндөр чанартай тэжээл шаарддаг, түргэн өсдөг, харьцангуй хөдөлгөөнтэй популяцид эзлэх хувь нэмэгдсэн. Удаан өсөлтийн хэлбэртэй ихэнх шаргачин эхний жилдээ үржилд ордоггүй, мөн тэдгээрийн ихэрлэлтийн эрчим доогуур байдаг ажээ. 1980-аад онд Тороор агнаж байсан нь энэ экоморф байгальд шалгаран үлдэж тоо толгой нь нэмэгдэхэд нөлөөлсөн.

1996 онд яагаад квот биелээгүй нь 1991-1996 оны хооронд байгалийн шалгарлын улмаас ердийн (хурдан өсдөг) экоморфын тоо өсөөгүйтэй холбоотой. Бэлчээрт энэ амьтдыг хангах тэжээлгүй байсантай холбоотойг үгүйсгэхгүй. Тоо толгойн бууралтыг дагасан популяцийн огцом өсөлтийн үндсэн дүр зургийг бид яагаад олж харэхгүй байна.

Энэ нь 19 зууны сүүлч, 20 зууны эхээр ажиглагдсан төлөв байдалтай адилхан байна (Жирнов, Максимук, 1998). Тухайн үед популяцийн бууралт 20-30 жил үргэлжилсэн бөгөөд зөвхөн дайны жилүүдийн өмнө тоо толгой нь өссөн байна. Хэрвээ бид 2000 онд популяцийн бууралт эхлэсэн гэж үзвэл популяцийн сэргэлт 10-20 жил болно.

Бид популяцийн бууралтыг урьдчилан харж чадахгүй байж магадгүй. Бид эсрэгээр бөхөн нэг хэсэг нь болох экосистемийн тэнцвэртэй бага бүтээмжит байдал, шинэ зүйлийн тухай ярих ёстой. Энэ нөхцөл байдлын өөрчлөлт 1980 оноос эхлэн 15 жилийн турш байсаар байна. Мөн Баруун хойд Каспийд газар авсаар байгаа популяцийн элбэгшил хэлбэлзэх нь тодорхой бөгөөд гэхдээ энэ нь популяцийн тооллогоор маш бага хэмжээтэй байна. Тэнд Казахстаны бөхөнгийн популяцид гүйцэтгэж байгаа адил төстэй анализ хийх хангалттай мэдээ алга. Гэхдээ өнгөрсөн зуунд, 1980-аад оны дунд үеэс эхлэсэн уг популяцийн динамикийн онцлог нь (бууралт, тоо толгойн ялимгүй өсөлт, огцом бууралт) хэдийгээр ялгаатай ч баруун хойд Каспийн популяцитай адилхан нөхцөл байдал байгааг харуулж байна.



Зургийн Анна Луцкекина

Баруун хойд Каспийн бүс дэхь бөхөнгийн популяци.

Узбекистаны мониторинг хөтөлбөрийн 2009-2010 оны үр дүн

Е.А. Быкова, А.В. Есипов

Узбекистаны ШУА-ийн амьтан судлалын хүрээлэн, Бөхөн хамгаалах нийгэмлэг, esipov@xnet.uz

Узбекистаны Устюртын бүс нутагт бөхөнгийн статусыг үнэлэхдээ шууд тооллогын өртөг, бусад хүчин зүйлээс хамааран орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурласан мониторингийг ашигласан. Бид Жаслик, Каракалпак, Кубла Устюрт тосгонд амьдардаг газар орноо сайн мэддэг анчдыг судалгаанд хамрууллаа. Бид 2009 оны 10 сараас 2010 оны 4 сар хүртэл уг нутагт Казахстанас бөхөн нүүдэллэн ирж байрших үед нь ороо хөөцөө, хойд зүг рүү чиглэсэн хаврын нүүдэл, төллөлтийн тухай мэдээ цуглууллаа.

Мониторинг судалгааны явцад нийт дүнгээр 5-50 бодгаль бүхий сүргийн 1217 бөхөн, үүнээс 36 эр, 1045 эм, 36 залуу, нас хүйс тодорхойлоогүй 100 бодгаль ажиглажээ. Энэ үед мэргэжилтнүүд бөхөнгийн тоо толгойг 2000 орчим толгой гэж үнэлсэн байна. 2009-2010 оны өвөл өмнөх жилийн өвөлтэй адилхан маш их цастай байсан ба цасны зуузаан 50 см орчим, зарим газраа 1 м хүрч байв. Өмнө зүг рүү чиглэсэн нүүдэл энгийн үеийнхээс сарын өмнө буюу 1 сард ажиглагдсан. Эргэж ирэх нүүдэл ердийн үеийнхээс хожуу буюу 3 сарын сүүл, 4 сарын эхээр ажиглагдсан. 1,2 сард гүнзгий цастай, хүчтэй салхитай байсан. Энэ үед замын нөхцөл байдал хүнд байсан бөгөөд орон нутгийн оршин суугчид тал руу явж чадахгүйн улмаас бөхөнгийн судалгаа цөөн хийгдсэн (энэ нь бөхөнд эерэгээр нөлөөлсөн). Цаг агаар арай дулаарсаны дараа 3 сард олон тооны судалгаа хийгдсэн. Өмнөх жилүүдийн адилаар тархацын хойд хэсэгт бөхөн бөөгнөрсөн байв.



Зургийг Александр Есипов

Бөхөнгийн мониторинг хийгдсэн Узбекистаны Устюртын хязгаарт бөхөнгийн нүүдлийг замыг хэлэлцэж байгаа нь.

Бид бөхөн хулгайгаар агнасан тохиолдол бүртгэсэн. Хулгайгаар агнагдсан нийт 91 бөхөн бүргэгдсэний дийлэнх нь эмэгчин байв. Хар зах дээр өндөр үнэлгээтэй, эрэлттэй байдаг эврийг олзворлохын тулд эр амьтныг агнадаг учраас популяцид оононы тоо толгой цөөн байсан нь энэ сонголтыг хийхэд хүргэсэн байна. Бүх насны ооно агнагдаж байна. Бие гүйцсэн шаргачингийн махыг ашиглахын тулд агнадаг (анчид өөрсдийн хэрэгцээндээ, түүнчлэн орон нутаг, олон улсад худалдаалах зорилгоор). Нэг агнуураар хамгийн ихдээ 10 орчим бөхөн агнадаг ба дунджаар 2,8 бодгаль агнадаг байна. Судалгааны явцад анчид Устюртын өмнө хэсэгт 4 хар сүүлтий хууль бусаар агнасан байна. Бидний болон бусад оролцогчдын мэдээллийг нарийвчлан оруулалгүйгээр хамгийн бага хэмжээнд үнэлэгдсэн болно. Гэхдээ тэд хулгайн ан эрчимтэй явагдсаар байгааг мэдээлсэн болно. Идэш тэжээлийн дутагдал болон махчдын улмаас байгальд үхсэн бөхөн ажиглаагүй байна. Устюртын Каракалпакийн хойд хэсэгт чонотой тулгарсан 2 тохиолдол бүртгэгджээ (2 мөр, 1-ийг биеэр харсан).

Бид 2007 оноос эхлэн Амьтан ургамлын аймгийг хамгаалах нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр энэ судалгааг хийв. Бид одоо удаан хугацаанд судалгаа хийх мэргэжилтнүүдийн сүлжээг байгуулахаар ажиллаж байна. Гэвч хамтран ажиллах шаардлагад нийцсэн хүнийг олох нь хэцүү юм. Хэрвээ арга зүйг хянан үзэж, цуглуулсан мэдээллийг шалган үзвэл бөхөнгийн популяцийн бүтэц, тоо толгойн мэдээллийг авах боломжтой харьцангуй өртөг багатай арга юм. Гэхдээ энэ арга зүй популяцийн албан ёсны тооллогыг орлож чадахгүй. Мэдээллийн үнэн зөв байдлыг сайжруулахын тулд судлаачын идэвхийг өсгөх, тэдгээрийн тоолох арга зүй, бүртгэх чадварыг боловсронгуй болгох, хээрийн судалгаанд хамааралтай багаж төхөөрөмжийг ашиглахад сургах хэрэгтэй. Энэ арга нь мониторинг хөтөлбөрийн хүрээнд ашиглагдаж байгаа бусад мониторинг судалгаанд (газрын болон агаарын тооллого, экологийн судалгаа) туслах чухал үүрэгтэй юм. Энэ аргын эерэг үр дүнгийн нэг бол хамгааллын нэмэлт арга хэмжээг төлөвлөхийн тулд мониторинг судалгаанд орон нутгийн хүмүүсийн оролцоог дэмжих явдал юм.

Волга-Уралын бүс дэхь бөхөнгийн учир битүүлэг үхлүүд

М.К. Сапанов

ОХУ-ын ШУА, Дендрологийн хүрээлэн, Жанибекск төв, sapanovm@mail.ru

Уралын популяцийн 12000 гаруй бөхөн 2010 оны хаврын төллөлтийн үед үхсэн (Бөхөнгийн мэдээ, №11) бөгөөд хэрвээ үүнтэй төстэй их хэмжээгээр үхсэн явдал 1984, 1988 онд бүртгэгдээгүй бол сонирхол татахааргүй байлаа. Амьтанд илэрдэг өвчин болох пастереллез нь үхлийн гол шалтгаан байсныг албан ёсоор мэдээлсэн. Мөн үхлийн шалтгаан нь хортой бодис хэрэглэснээс үүдсэн гэж бусад эх сурвалжууд мэдээлж байна. (<http://www.inform.kz/rus/article/2274833>). Гэхдээ эдгээр таамаглалын аль нь ч үхэж буй эхийнхээ сүүгээр хооллож байсан янзагануудын эсэн мэнд үлдэлтийг тайлбарлаж чадаагүй.

Миний бодлоор, энэ үхэл хорогдол цочмог хэлбэрийн хэвлийн хавдарын улмаас багтраа үүссэнээс үүдсэн гэж бодож байна. Нойтон ургамлаар хооллосны улмаас ургамлын үлдэгдлийн исэлт явагдсанаар энэ байдалд хүргэсэн байна. Тухайн үеийн нөхцөлд байдалд хийсэн олон талт шинжилгээ, түүнчлэн Уралын популяцийн тархац нутагт байрлах бөхөнг зориудаар үржүүлэх Жанибекск төвийн удаан хугацааны туршлага дээр үндэслэн энэ тайлбарыг хийж байна. Орос, Казахстаны хил дээр байдаг Жанибекск төвийг Казахстаны ШУ, ойн үйлдвэрлэлийн төв, ОХУ-ын ШУА-ийн Дендрологийн хүрээлэн хамтран ажиллуулдаг. Энд Б.Д.Абатуров, К.О.Ларионов, В.И.Петришев, А.Е.Субботин, М.В.Холодова нар 2007 он хүртэл зориудын нөхцөлд үржүүлж байгаа бөхөнгийн идэшлэх үеийн зан төрхтэй холбоотой судалгааны ажил хийж байв. Бөхөн төллөх үе нь ургамал ургах үетэй

давхцдаг. Хэрвээ борооны дараа ургамал маш ихээр норсон байвал, ялангуяа идэш тэжээл дэхь шошны төрлийн ургамал гэдэсний цочмог хэлбэрийн өвчнийг үүсгэдэг байна. Хээрийн царгас, шош нь хивэгч амьтдын гэдсэнд ургамлын үлдэгдэл исэх процессын гол хурдасгуур болдог байна.

Бөхөн төллөлт явагдсан нутгийн 2010 оны экологийн нөхцөлд анхаарлаа хандуулъя. Бөхөн энэ газарт анх удаа ирсэн байсан. Волга-Урал нь давсархаг бүс нутаг бөгөөд өндөрлөг газар цөл, заримдаг цөлийн ургамлын бүлгэмдэл, нам дор газар, хээрийн бүсэд багасаж хээрийн царгас зэрэг үр тарианы ургамлын бүлгэмдэл зонхилсон ургамлан бүрхэвчтэй байна.

Уг бүсэд 5 сарын 14-ний шөнө 42,6 мм (дунджаар 27 mm) хур тунадас орсон байна. 40 мм-ээс илүү хур тунадас орох нь уг бүсэд маш ховор тохиолддог (59 жилд 6 тохиолдол). Үүний улмаас бүх нам дор газар усаар дүүрч ургамал маш нойтон байв. 5 сарын 15-ны шөнийн 8 цаг хүртэл үргэлжилсэн. 5 сарын 16 ны шөнө дахин бороо орсон (3мм). Бидний харсанчлан бөхөн үхэх хугацаанд цаг агаар маш их чийгтэй байв.

Бөхөнгүүд дөнгөж үүр цаймагц идэвхтэй идээшлэн, нойтон ургамлыг идэж байсан. Бидний хүсэлтээр К.О.Ларионов үхсэн бөхөнгийн гэдсэн дэхь ургамлын үлдэгдлийн бүрдлийг судалсан. Үүний үр дүнгээр үхсэн амьтдын идэш тэжээлийн 93 хувь нь шошны төрлийн ургамал, өвс, бутархаг ургамал байсан байна. Мөн царгас (26%) илүү байсан ба *Medicago* sp., *Potentilla* sp. and *Polygonum* sp зүйлүүд тохиолдож байв.



Бөхөн ихээхэн үхсэн газар нутгийн нийтлэг дүр төрх, 2010 оны 8 сар.

Зургийг Павел Сапанов

Чийгтэй, залуу царгасаар хооллосон гэрийн хивэгч амьтдын гэдэс хөөдөгийг үндсэндээ хүлээн зөвшөөрсөн бөгөөд бөхөн энэ шалтгаанаас болж үхсэн байна. Цастай хүйтэн өвлийн дараах хавар нүүдэллэсэн бөхөнгүүд ихээхэн сульддаг бөгөөд төрсний дараа сульдсан шаргачингүүд ихээр үхэх явдал гардагийг анхаарууштай. Яагаад ооно үхдэггүй нь тэд өөр газар байдагтай холбоотой бололтой. Амьд үлдсэн залуу бөхөнгүүдийн жижиг сүрэг төллөсөн газартаа намар хүртэл байдаг (шүүлсэг ургамлаар хооллоход тэд хэт бага байдаг бололтой).

Мянга мянган эм бөхөн үхсэний далд учир

шалтгааныг бид туршилтаар баталгаажуулсан нь чухал ач холбогдолтой юм. Байгалийн энэ нөхцлөөс хамгаалах ямар нэгэн арга байхгүй байгаа ба хамгааллын арга замыг бүрэн боловсруулах боломжтой. Миний бодлоор Жанибекск төвийн судалгаа шинжилгээний материал, дэд бүтцийг ашиглан БНГ-т ("Бокейорда-Зайк") хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа хөтөлбөрийн нэг хэсэг болгон эрдэм шинжилгээний судалгаа хийх боломжтой юм.

Миний бие бөхөн судлаач В.Д.Абатуров, К.О.Ларинов, И.К.Илимисов нарын зөвлөгөө, тусламжид талархаж байна.

Хамгааллыг төлөвлөх зорилготой “Биосан” программ


Долгоржав Санжмятав

Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Биосан бол амьтны тархцын орон зайн мэдээлэл, хөхтөн болон шувууны популяцийн бүтэц, элбэгшлийн мэдээг боловсруулах, нэгтгэх, цуглуулах зорилгоор хийгдсэн газарзүйн мэдээллийн систем дээр суурилсан өгөгдөл бүхий мэдээллийн сангийн программ юм. Энэ программыг янз бүрийн амьтдын тархац нутагт бодит хугацаанд ижил арга зүйг ашиглан хийсэн мэдээллийг боловсруулах, популяцийн бүтэц, тархалтын орон зайн болон улирлын ялгааг задлан шинжлэхэд ашиглаж болно. Энэ нь зэрлэг амьтдын хамгааллын төлөвлөгөө, хамгааллын үйл ажиллагааг хэрэгжүүлэх, боловсронгуй болгоход үндэс суурь болно. Эхэндээ энэ программ ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс

боловсруулан гаргасан уулын, ойн, тал хээрийн туруутан, цоохор ирвэс, монгол тарвага, усны шувуудын анхдагч мэдээллийг цуглуулах зорилготой бүтээгдсэн. Сүүлд энэ программыг ДБХС-гийн Монгол дахь хөтөлбөрийн газрын дэмжлэгтэйгээр боловсронгуй болгож, зохиогчийн эрхийг авсан.

Биосан программаар зэрлэг амьтдын амьдрах орчны анхдагч мэдээллийг эрдэмтэн судлаачдад дүрслэн харуулах боломжтойгоос гадна шийдвэр гаргах түвшинийхэн, хамтран ажиллагч байгууллага, ивээн тэтгэгчдэд боловсруулсан, оруулсан мэдээллийг түргэн, найдвартай аргаар хүргэх боломжтой.



Диagramм 1. Программын бүтэц

Гуанжоуд хийгдсэн бөхөн хамгаалахад чиглэгдсэн асуулгын судалгаа

Фенглиан Ли

Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөрийн газар, fli@wcs.org

Хамгааллын мэдлэгийг дээшлүүлэх, Хятадын уламжлалт анагаах ухаанд хэрэглэгдэж байгаа бөхөнгийн эвэр, бусад ховордсон зүйлүүдийн эд эрхтний хэрэглээг багасгахын тулд Хятад дахь Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг Гуанжоу дахь хятадын уламжлалт анагаах ухааны (ХУАУ) бөөний төвийн ойролцоо автобусаар аялан зар сурталчилгаа хийх ажлыг санаачилсан. Энэ компани ажил 2010 оны 2 сараас 7 сар хүртэл үргэлжилсэн бөгөөд ХУАУ-ны бөөний төвөөр дамжин өнгөрдөг зам дагуу 6 номерын 10 автобусанд 2 удаа зар сурталчилгааны ажил хийсэн. Зургаан сарын туршид 150000 гаруй хүн оролцсон нь зар сурталчилгаа үр дүнтэй болсныг харуулна.



Зургийн Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэг

Туслах ажилчид асуулгын судалгаа авч байна.


Худалдааны төвд олон дахин ирж байгаа хүмүүст бөхөн хамгаалах мэдлэгийг ойлгуулснаар автобусны аялалын дараах тэдний хандлага, мэдлэг, зан байдлыг үнэлэхийн тулд Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь хөтөлбөр компани ажлын өмнө болон дараа хоёр удаа судалгаа хийсэн. Нийтдээ 413 болон 460 хариулт тус тус цуглуулсан байна.

Компани ажлын өмнөх ба дараах судалгаа нь автобусаар хийсэн зар сурталчилгааны ажил нь хамгааллын мэдээллийг ард иргэдэд өргөн хүрээтэй хүргэж чадаагүйг харуулж байна. Гэхдээ хариултын зарим нь зар сурталчилгааны ажил тодорхой мэдлэгийг олгосон болохыг илтгэв. Компани ажил дууссаны дараа асуулгад оролцогчдын 75% нь бөхөнгийн эврийг анагаах ухаанд ашиглагдаас болж цөөрч байгааг хүлээн зөвшөөрсөн нь өмнөх судалгаанд оролцсон хүмүүсийн 55% ингэж хариулсантай харьцуулахад өссөн байна (Диэг. 1). Хэдийгээр хүмүүсийн хандлага онцын өөрчлөлтгүй байгаа ч зарим асуулгын судалгаанд оролцогчид бөхөн зэрлэг амьтдын хууль бус худалдаанаас шалтгаалан устаж байгааг ойлгосон байв. Энэ судалгаа бөхөн хамгаалалд үндсэндээ эерэг нөлөөг үзүүлсэн байна.

Асуулгад оролцогчдын 55% нь бөхөнгийн эврийг хууль бусаар худалдаалагддаг болохыг мэдсэн бол, 65% нь бөхөнгийн эврийг хятадын уламжлалт анагаах ухаанд тогтворгүй ашиглах нь дэлхий дахины бөхөнгийн популяцид нөлөөлөх болно гэж үзсэн ба 35% нь бөхөнгийн эврийг анагаах ухаанд ашиглаж байгаа шиг тэжээвэр одос үхрийн эврийг ашиглаж чадна гэж хүлээн зөвшөөрчээ.

Ерөнхийдөө энэ бүс нутгийн хүмүүст бөхөн рүү чиглэсэн эерэг хандлага байгаа бөгөөд тэдний зарим нь Засгийн газар, зэрлэг амьтан хамгаалах байгууллагын хийсэн зэрлэг амьтны хамгааллын тухай видео, телевизийн хөтөлбөрийг үздэг байна.

Хэдийгээр автобусаар зар сурталчилгаа явуулах нь хамгааллын мэдлэгийг дээшлүүлэхэд үр дүнтэй нөлөө үзүүлж чадаагүй ч хамгааллын тухай олон нийтийн мэдлэг нэмэгдсэн болохыг бидний судалгааны үр дүн харуулж байна. Хүмүүс хамгааллын мэдээллийг телевиз, интернет, гар утас, сонин зэрэг олон талын арга замаар хүлээн авдаг бөгөөд автобусанд дахь компани ажил сонирхол татахгүй байна. Ирээдүйн боловсрол, компани суртал нэвтрүүлэг нь хамгааллын мэдээллийг олон нийтэд илүү үр дүнтэй хүргэх арга замыг боловсронгуй болгох судалгааны үр дүнг авч хэлэлцэнэ.



Диэграм 1.

Автобусаар зар сурталчилгаа хийхийн өмнө болоод хийсний дараа асуулгын судалгаанд тийм гэж хариулсан хүмүүсийн эзлэх хувь

Асуултууд:

- 1) Хятадын уламжлалт анагаах ухаанд бөхөн эвэр ашиглагддаг талаар та сонсож байсан уу?
- 2) Бөхөнгийн эврийг хууль бусаар худалддаг гэж та боддог уу?
- 3) Өнгөрсөн 6 сарын дотор уламжлалт эмчилгээ болох бөхөнгийн эвэр худалдаж авсан уу?
- 4) Хятадын уламжлалт анагаах ухаанд бөхөнгийн эврийг ашигласнаар тэдгээрийн популяцид нөлөөлөхийг та хүлээн зөвшөөрөх үү?
- 5) Бөхөнгийн эврийг ордуулан тэжээвэр одос үхрийн эврийг ашиглахыг та зөвшөөрөх үү?
- 6) Та өмнө нь 6 номерын автобусаар зорчиж байсан уу?
- 7) Сүүлийн 3 сард зэрлэг амьтан хамгааллын тухай зар сурталчилгаа үзсэн үү?

Бөхөнгийн баатрууд

Редакцийн тэмдэглэл:

Бөхөнгийн мэдээний энэ шинэ бүлэгт бид бөхөн хамгаалад томоохон хувь нэмэр оруулсан хүндэт хүмүүсийг оруулах болно. Бид бөхөн хамгаалахад зорулан бүх улс оронд янз бүрийн ажил хийж байгаа хүмүүсийг дүрслэн харуулна. Бидний анхны Бөхөнгийн баатар бол профессор Аманкул Бекенов юм. Хэрвээ та бөхөнгийн баатарт нэрээ дэвшүүлмээр байвал [E.Быковатой](mailto:E.Milner@imperial.ac.uk) холбогдоно уу.

Бөхөн хамгаалах нийгэмлэгийн анхны хүндэт гишүүн профессор Аманкул Бекенов



Зургаа: Е.Ж.Милнер Гулланд

Профессор Бекенов миний бяцхан хүү
Романтай тоглож байна.

Монгол улсын нийслэл Улаанбаатар хотноо 2010 оны 9 сарын 11 нд болсон Бөхөн хамгаалах нийгэмлэгийн жилийн уулзалтан дээр профессор Аманкул Бекеновын бөхөн хамгаалахад зориулсан олон жилийн цуцалтгүй хөдөлмөрийг үнэлэн бөхөн хамгаалах нийгэмлэгийн анхны хүндэт гишүүн болгохоор шийдвэрлэсэн. Бөхөн хамгаалах нийгэмлэгийн удирдах зөвлөл олонд танигдсан энэ эрдэмтнийг сонгосондоо баяртай байна. Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дарга миний бие энэ хүнтэй удаан хугацаанд найзалж хамтран ажиллаж байсны хувьд хувь хүнийхээ өмнөөс хүндэтгэл үзүүлж байна. Аманкул Бекеновын судалгаа хөхтөн амьтны тархац нутгийн хамгаалал, экологи руу чиглэж байсан ба хээрийн судалгаа, боловсруулалтыг хийж байв. Түүний шинжлэх ухааны ур чадварыг үнэлэн 1982 онд Казахстаны БНУ-ын төрийн шагналыг түүнд гардуулсан байна. Тэрээр 1969-1985 оны хооронд 4 ном хэвлүүлсэн бөгөөд түүний бичсэн “Казахстаны хөхтөн амьтад” ном, мөн хамтран оролцсон багийн хамт олон байгаль хамгааллын судалгааны түүхэн дэхь хамгийн сайн ажил болсны хувьд Москвагийн байгаль судлаачдын нийгэмлэгийн анхны шагналыг 1988 онд хүртсэн байна. Профессор Бекенов бөхөн хамгаалах талаар ажилладаг тэргүүлэх мэргэжилтэн доктор Юрий Грачевтай хамтран Казахстаны бөхөнгийн хамгаалал, экологийн талаар олон өгүүлэл, ном бичсэн. 1978-2010 оны хооронд дархан цаазтай 40-өөд амьтны экологи, хамгааллын мэдээллийг тусгасан Казахстаны улаан номын хөхтөн амьтны хэсгийн зохиогчоор ажилласан.

Профессор Бекенов Казахстаны ШУА-ийн амьтан судлалын хүрээлэнгийн захирлаар олон жил ажиллаж байсан. Одоо тэр тус хүрээлэнгийн Териологийн лабораторийн эрхлэгчээр ажиллаж байгаа бөгөөд зэрлэг ан амьтдыг хамгаалах, менежментийн талаар төрөөс баримталж буй бодлогын шинжлэх ухааны хэсгийг тэргүүлдэг ба Казахстаны хөхтөн амьтад хандсан Хүрээлэнгийн судалгааны хөтөлбөрийг удирдан чиглүүлдэг байна. Казахстаны зэрлэг ан амьтдын менежментийн бодлогын амжилтын нэгээхэн хэсэг нь Профессор Бекенов, түүний лабораторийн олон жилийн нөр их ажлын үр дүн юм.

Би Казахстанд анх очих үедээ Профессор Бекеновтой танилцсан юм. Би бөхөнгийн экологийн судалгааны асар өндөр ур чадвартай томоохон төвд ажиллаж байсан түүнтэй болон түүний багтай уулзахдаа маш их баяртай байсан ба тэдний олон өгүүлийг уншиж байв. Профессор Бекенов маш зочломтгой байж, урам өгсөн бөгөөд эндээс эхлэн хамтарсан судалгааг эхлүүлж одоог хүртэл хамгаалалтай холбоотой цоо шинэ судалгааны үр дүнг хийсээр байгаа ба Төв Ази, Европын судлаачдын хооронд олон улсын хамтын ажиллагааг хөгжүүлсэн. Энд хийгдэж байсан бидний ажил эхний жилүүдэд INTAS-аар дамжин Европын холбооноос санхүүжиж байсан бөгөөд бөхөн, гэрийн малын өвчин, паразит, бөхөнгийн нүүдлийн экологиод газар нутгийн доройтлын нөлөө, генетикт чиглэж байв.

Эдгээр жилүүдийн туршид миний бие зөвхөн өөрийн судалгааны төсөл биш, өөрийн их сургуулиас түүний лабораторид ажиллуулахаар явуулсан оюутнуудад Профессор Бекенов тусалж дэмжиж байгаал ихээхэн талархаж байна. Эдгээр залуу судлаачдын хожим гаргах амжилт нь түүний удирдлага, тусламж, түүний багийн судалгааны ур чадварын нотолгоо юм.

Профессор Бекенов бөхөн хамгаалах нийгэмлэгийг үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд энэ зүйлийг хамгаалах, судлахад олон улсын хамтын ажиллагааны үр нөлөөг ихээхэн дэмждэг юм. Тэрээр бөхөн хамгаалах нийгэмлэгийн төлөө идэвхтэй ажиллаж байсан бөгөөд бөхөн мэдээ сэтгүүлийн редакторын зөвлөлд ажиллаж дугаар бүрийг шинжлэх ухааны үнэн зөв, ур чадвартай мэдээгээр хангадаг. Би Профессор Бекеновын найз, хамтран зүтгэгч болсондоо баяртай байгаа ба түүнтэй хамтран олон жил ажиллах болно.

Е.Ж. Милнер-Гулланд,
Бөхөн хамгаалах нийгэмлэгийн дарга,
e.j.milner-gulland@imperial.ac.uk

Төслийн тойм

Устюртын өндөрлөгийн аж үйлдвэрийн хөгжил доторхи Биологийн төрөл зүйлийн хандлага



Узбекистаны тал нутаг нь дэлхийн хэмжээнд ургамал амьтны идээшил нутаг хуурайшиж байгаа сүүлийн жишээний нэг юм. Узбекикийн тал нутагт нүүрлэж буй гол аюул нь газрын тос, хийн олборлолтын хэмжээ нэмэгдэж байгаа байдал юм. Нэгдсэн үндэстний байгууллагын Даян дэлхийн байгаль орчны сан 2010 оноос “Узбекистаны газрын тос, хийн бодлого, үйл ажиллагаан дахь биологийн төрөл зүйлийн хандлага” төсөл хэрэгжүүлж эхлэсэн. Энэ төслийн зорилго нь Узбекистаны газрын тос, хийн бодлого, үйл ажиллагаан дахь биологийн төрөл зүйлийн хандлага, Устюртын өндөрлөгийн хэрхэн үүнийг хийж чадахад чиглэдэг.

Төслийг Узбекистаны байгаль хамгааллын үндэсний хороотой хамтран хэрэгжүүлж байна. Төслийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд мэдлэг, засаг захиргааны бэрхшээлийг системтэйгээр байхгүй болгох хэрэгтэй бөгөөд үүнийг 2 үндсэн арга замаар хийх болно:

1) Газрын тос, хийн салбарт биологийн төрөл зүйлийн хамгааллыг хөндсөн хандлагыг хэрэгжүүлэхийн тулд хүрээлэн буй орчны хууль тогтоомж, бодлогыг шийдвэрлэх; 2) Устюртын өндөрлөгт явагдаж буй газрын тос, хийг олборлох үйл ажиллагааны технологийг биологийн олон янз байдлын хандлагад тохируулах



Зургийг Денис Нурдоджанов

Устюртын өндөрлөгийн гайхалтай дүр төрх.

Энэ төслийн ойрын зорилт нь дэлхийн 2 сая га-гаас илүү том нутагт эерэг нөлөөг бий болгох юм.

Энэ нь жороо тоодог, цөлийн үнэг, хар сүүлт, Устюртын аргаль, бөхөн зэрэг аюулд учирч буй зүйлүүдийн популяцийг тогтвортой байдлыг хангана.

Төслийн урт хугацааны зорилт нь Узбекистаны газрын тос, хийн салбарт хийгдэж байгаа болон, ирээдүйд хийгдэх бүх үйл ажиллагааны биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, нөлөөлөлд өртөж байгаа экосистемийг хамгааллын хэтийн төлөвлөгөөг сайжруулахад чиглэгдэж байна.

- Системтэй, тодорхой үе шаттай үйл ажиллагаа нь төсөл хэрэгжиж дууссаны дараа уг газар нутгийн хүрээлэн буй орчныг хамгаалах үйл ажиллагааг илүү далайцтай өрнүүлэхэд туслах болно.
- Туршилтын бүсэд явагдаж байгаа үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчныг хамгаалах шинэ арга замыг бий болгох, шалгах, “үнэнд суурилсан” шинэ хууль, бодлогоор хамтран ажиллагч талуудыг хангах болно.

Дэлгэрэнгүйг Хүрээлэн буй орчин, Энергийн газрын дарга ноён Абдуваккос Абдурахмановтай холбогдож авна уу, abduvakkos.abdurahmanovundp.org.



Зургийг Александр Естинов

Устюртын өндөрлөгийн өвөл.

SOS (байгаа зүйлүүдийг хамгаалал)-аас Уралд хэрэгжүүлж байгаа бөхөн хамгаалах шинэ төсөл



“Уралын бөхөнгийн популяцийн үхэл хорогдлыг зогсоох, хамгаалахын тулд олон нийтийн үүргийг бий болгох” төслийг Save Our Species хөтөлбөр, Ховордож буй амьтан хамгаалах хүмүүсийн сан, Амьтан ургамлын аймгийг хамгаалах олон улсын нийгэмлэг, Дисней зэрлэг амьтан хамгаалах сан хамтран хэрэгжүүлж байна. Уралын популяцид 2010 оны 5 сард бөхөн ихээхэн хорогдсоноос үүдэн Бөхөн хамгаалах нийгэмлэг энэ төслийг санаачилсан (Бөхөнгийн мэдээ, №11). Казахстан дахь төслийн удирдагчаар Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (КБТЗХН) ажиллаж байгаа ба Казахстан Хөдөө аж ахуйн яамны Ой ангийн хороо (ОАХ), Баруун Казахстан дахь ОАХ-ны бүс нутгийн салбар, орон нутгийн засаг захиргаа, сургууль, орон нутгийн иргэд оролцож байна. Төслийн судалгаанд Лондонгийн эзэн хааны коллеж, Уралын их сургууль хамтран ажиллах болно.

Төслийн боловсрол, мэдээллийн ажлын хүрээнд бөхөнгийн ном, тал хээрийн зүйлүүдийн экологи, экосистемийн талаар боловсрол олгох зорилготой үзүүлэнг төсөл хэрэгжих газрын сургуулийн багш нарт тараан өгөх болно. Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэгийн гишүүдээс гадна Уралын их сургуулийн оюутнуудын клуб, эрдэмтэн судлаачид төсөл хэрэгжиж буй нутгийн өөр өөр газарт бөхөнгийн тухай кино үзүүлж, материал тараан, мэдээлэл өгөх уулзалтыг гүйцэтгэх болно.

Эцэст нь бөхөн судлах экспедицийг зохион байгуулна. Эдгээр бүх үйл ажиллагаа нь сүүлийн цөөн жилд хүний үйл ажиллагаанаас шалтгаалан тоо толгой нь эмгэнэлтэйгээр буурч байгаа Казахстан тал нутгийн билэг тэмдэг болсон бөхөн рүү чиглэсэн энэрэнгүй хандлагыг бий болгоход чиглэгдэж байна.

Төслийн үр дүн, бүтээмжийг үнэлэхийн тулд төслийн эхэнд ба хэрэгжиж дууссаны дараа орон нутгийн ард иргэдийн дунд судалгаа явуулна. Энэ нь Бөхөн хамгаалах хүмүүсийн хандлага, энэ зүйлийн биологи, экологийн талаарх тэдний мэдлэг хир зэрэг нэмэгдсэн, тал хээрийн экосистемийн сэргэлт зэргийг харах болно. Энэ төслийн өөр нэг чухал тал нь бөхөнгийн тархач нутагтай шууд хөршлөн амьдарч байгаа орон нутгийн иргэдийг оролцуулсан бөхөнгийн мониторинг хөтөлбөрийг бий болгох юм. Мэдээллийн үйл ажиллагааг энэ мониторинг хөтөлбөрт оролцож байгаа хүмүүс явуулна гэж урьдчилан төлөвлөж байна. Төсөл хэрэгжих газарт 2010 оны 12 сард болсон урьдчилсан уулзалтанд орон нутгийн засаг захиргаа, сургууль, судлаачид зэрэг бүх оролцогч талуудад төсөлтэй холбоотой тэдний сонирхол, төсөлд оролцоход бэлэн эсэх, төсөлтэй холбоотой бүх үйл ажиллагааны дэмжлэг зэрэг асуудлуудыг хэлэлцсэн.

Дэлгэрэнгүйг төслийн зохицуулагч Ольга Климановагийн olga.klimanova@acbk.kz хаягаар авна уу.

Бөхөн хамгаалах нийгэмлэгээс 2010 онд жижиг төслийн тэтгэлэг авсан хүмүүсийн танилцуулга



Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ (WCN), Зэрлэг амьтан хамгаалах олон улсын зөвлөл (CIC) Бөхөн хамгаалах нийгэмлэгийн 2010 оны жижиг тэтгэлгийн хөтөлбөрийн хүрээнд санхүүгийн дэмжлэг үзүүлэхийн тулд 4 улсаас авъяаслаг бөхөн судлаачдыг сонгохыг бидэнд зөвшөөрсөн. Энэ хөтөлбөр нь 1 жилийн хугацаанд 2000 ам доллар хүртэлх санхүүжилттэй, бөхөнг байгальд нь хамгаалах үйл ажиллагааг дэмждэг. Бүх төсөл нь бөхөн хамгаалахад чиглэгдсэн Зэрлэг амьтдын нүүдэллэдэг зүйлүүдийг хамгаалах конвенцийн харилцан ойлголцлын санамж бичгийн ОУДХАХ-т заагдсан эн тэргүүнд хийгдэх, ялангуяа цагаа олсон, хамгаалал зайлшгүй шаардлагатай тодорхой газар нутагт нөлөөлж буй хүчин зүйлийг

арилгахад хандсан байх ёстой.

Шалгаруулалтын үндсэн зорилго нь хүмүүсийг чадавхижуулах, ялангуяа өөрсдийн хийж байгаа ажилдаа олон улсын томоохон төрийн бус байгууллагуудаас санхүүгийн дэмжлэг авах боломжгүй хүмүүсийг сонгох явдал юм. Бид өнгөрсөн жилийн тэтгэлэг авсан хүмүүсийг дэмжих ажлаа үргэлжлүүлсээр байгаа ба тэднийг Бөхөн хамгаалах нийгэмлэгт авчирснаар бид тэдэнд өөрсдийн ажлаа үргэлжлүүлэх урам зориг, нөөц бололцоог авахад тусалж чадна. Энэ жил бид янз бүрийн газарт өргөн хүрээтэй асуудлыг шийдвэрлэхээр тэтгэлэг авсан 4 маш сайн ялагчид гардууллаа.

Фенглиан Ли, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн (WCS) Хятад дахь хөтөлбөрийн газрын ажилтан тэрээр Хятад улсын Гуанжоу дахь бөхөнгийн эврийн хууль бус худалдааг шийдвэрлэх зорилготой Гуйонг Зангийн жижиг төслийн тэтгэлэгийг авч 2009 оны ажлаа улам өргөжүүлсэн байна (Бөхөнгийн мэдээ №11-ийн эхний өгүүллийг хар).



Фенглиан Жингпинг дэхь Хятадын уламжлалт анагаах ухааны худалдааны төвд бөхөнгийн эврийн худалдааны түвшинг хянах, энэ худалдаанд оролцож байгаа хүмүүст боловсрол мэдлэгийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг гүйцэтгэх, орон нутгийн уламжлалт анагаах ухааны төвүүдэд хууль хэрэгжүүлэхийг дэмжих зэрэг ажилд чиглэн үргэлжлүүлэн ажилласаар байна.

Гуйонг Зангийн төслийн үр дүнд Гуанжоугийн хятадын уламжлалт эмийн захын бөхөнгийн бүтээгдэхүүний үнэ, олдоцыг тогтоосон. Фенглиан газарзүйн үүднээс боловсрол ба хуулийн хэрэгжилтийн үр дүнд гол анхаарлаа хандуулахыг дэмжих, худалдааны үндсэн механизмыг бүрэн гүйцэд ойлгохын тулд бөхөнгийн бүтээгдэхүүний зам, эцсийн хүрэх газар, нөөцийг тогтоохоор энэ ажлыг өргөжүүлэхийг төлөвлөж байна. Фенглианы ажил бол бөхөн хамгааллын уламжлалт байдалтай тохирч байгаа газарт бөхөнгийн хууль бус худалдааны эрэлт хэрэгцээний талыг хөндсөнөөрөө илүү ач холбогдолтой юм.

Гүндэнсамбуугийн Гүнбат бол бөхөнгийн экологи, хамгааллын чиглэлээр эрдмийн зэрэг хамгаалахаар суралцаж байгаа МУИС-ийн магистрант оюутан. Монгол бөхөнгийн экологи Гүнбатын өмнөх судалгааны ажлаар хийгдсэн бөгөөд энэ нь түүний магистрын зэрэг горилох дипломын ажлын суурь материал болно.



Гүнбат монгол бөхөнгийн идэш тэжээлийн судалгаанд уг тэтгэлгийг ашиглаж байгаа ба үр дүнг гэрийн малын идэш тэжээлтэй давхцуулан үзэх болно. Бөхөнгийн хамгаалалд ихээхэн саад учруулж байгаа хоёр зүйлийн хоорондох идэш тэжээл, усны төлөө өрсөлдөөний талаар гайхалтай нотолгоо байгаа боловч албан ёсны судалгаа хараахан хийгдээгүй байна. Баруун Монголын Шаргын говийн БНГ-т хийгдэх Гүнбатын ажил нь энэ асуудлыг хөндөж байгаа бөгөөд хүн ба бөхөн хамтын амьдралыг дэмжсэн тогтвортой газар ашиглалтыг төлөвлөх явдлыг бий болгоход ашиглаж болох юм.

Айзада Нурумбетова бол Узбекистаны Каракалпакстан дахь эмэгтэйчүүдийг нийгэмд дэмжих төв болох “Keuil nury”-н захирал юм. Нурумбетовагийн грант нь орон нутгийн эмэгтэйчүүдийг зүүгээр урлах, хаггамал хийх, гар урлалын бүтээгдэхүүн хийхэд сургаснаар Узбекистаны Устюртын өндөрлөгт оршин суугчдын орлогын эх үүсвэрийг бий болгоход ашиглагдана. Энэ нь орлогын өөр эх үүсвэрийг бий болгосноор хууль бус агнуур хийх шаардлагыг багасгах, мэдлэгийг өсгөх гэсэн 2 зорилготой. Үнэндээ гар урлалд сурсан эмэгтэйчүүд өөрсдийн гэр бүл, нөхөрлөлд бөхөн хамгааллыг дэмжих боломжтой. Энэ төсөл Жаслик тосгоны эмэгтэйчүүдийн хамтын ажиллагааг бий болгоход зарцуулагдах бөгөөд бусад тосгонд хөтөлбөрийг хэрэгжүүлэх болно.



Павел Амасов бол Оросын Астрахан мужийн Богдинск Баскунчак БНГ-ын судалгаа шинжилгээ хариуцсан орлогч захирал юм. Амасов нөөц газарт 2 жил ажиллаж байгаа бөгөөд уг газрын сээр нуруутан амьтдын популяцийн төлөв байдлыг хянах ажлыг хариуцдаг. Энд томилогдохоосоо өмнө тэр их сургуулийн амьтан судлалын хэсэгт сээр нуруутан амьтдын талаар лекц уншдаг байсан бөгөөд лекц унших түүний ажил үргэлжилсээр байна. Тэр Баскунчак нуураар дайран өнгөрөх бөхөнгийн нүүдлийн зам, тархац, тоо толгойг судлахын тулд тэтгэлгийн мөнгийг ашиглана. Энэ мэдээлэл нь нүүдлийн явцад бөхөн хамгаалах асуудлыг дэмжих, дамжин өнгөрөх хэрэгслийг бий болгоход ашиглагдана.

Тэтгэлэг авсан 4 ялагчдаа баяр хүргэе!

БӨХӨНГИЙН ШИНЭ ӨГҮҮЛЭЛ

Singh, N., Milner-Gulland, E.J. (2011) Conserving a moving target: Planning protection for a migratory species as its distribution changes. *Journal of Applied Ecology* **48**, 35-46.

Сүүлийн 25 жилийн туршид хийсэн агаарын мониторинг мэдээг ашиглан Казахстаны Бетпак-дала дахь бөхөнгийн нягтшилыг гаргасан бөгөөд хаврын тархцын өөрчлөлтийг тодорхойлсон. Мөн уур амьсгалын өөрчлөлттэй холбоотой тархац нутгийн өөрчлөлт, популяцийн хэмжээг хамгаалах газар нутгийг тодорхойлох ажил хийсэн.

Өнөөгийн тархац нутагт өнгөрсөн үеийн цаг агаар нөлөөлөл, эмх замбараагүй байдал хүчтэй нөлөөлсөн. Байршихад тохиромжтой газар нутаг өнгөрсөн арван жилд 2 дахин багасаж, тасархайтсан байна. Ирээдүйн байгаль цаг уурын ихэнх үзэгдлийн дор ажиллах, харилцан бие биенээ нөхсөн ТХГН-ууд одоо байгаа ба шинээр санал болгож байна. Хэрвээ ирээдүйд тохиромжтой газрууд үр дүнтэй хамгаалагдаж байвал ТХГН-ийг төлөвлөхдөө газарзүйн цар хүрээг том байлгах хэрэгтэй.



Зургийг Навиндер Синх

Залуу эм бөхөн

Талархал

Бөхөн хамгаалах нийгэмлэг сүүлийн 6 сарын турш бидний үйл ажиллагааг дэмжсэн доорх хүмүүст чин сэтгэлийн талархал илэрхийлье: Chuck ба Judy Wheatley, Dr. Marjorie Parker, Joy Covey ба түүний 5 настай хүү, Tyler, Steven and Karin Chase, Dr. Jim Sanderson and Joan Morrison, Linda Tabor-Beck, Kent and Gloria Marshall, Susan Combs, Michael Hackett, Kevin and Kim Nykanen, CC Lobos, G Evans, B Reinartz, M Moppett, G Elliot, N Colloredo. Зэрлэг амьтан хамгаалах сүлжээ Үзэсгэлэн-2010-ын турш Бөхөн хамгаалах нийгэмлэгийг хувиараа хүлээн авч байсан ивээн тэтгэгч, бидний эртний найз Kenyon and Bob Hudson нар тусгайлан талархаж байна. Мөн манай ажилд туслаж байсан WCN болон FFI-ийн ажилчид, сайн дурынханд, WCN үзэсгэлэнгийн долоо хоногийн Бөхөнгийн мэдээ сэтгүүлийн өмнөөс зураг авах ажлыг олон жил хийсэн нэртэй зурагчин Мартин Варонд талархлаа илэрхийлье. Бид мөн энэ дугаарыг гаргахад дэмжлэг үзүүлсэн WCN, Мухамед бин Завед сан, Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Зэрлэг амьтан хамгаалах нийгэмлэгийн Хятад дахь салбарт талархалаа илэрхийлье.

Редакцийн зөвлөл. Хятад: Г. Занг & док А. Канг, WCS China (gzhang@wcs.org; akang@wcs.org); Казахстан: Профессор А. Бекенов & док Ю.А. Грачев, Зоологийн хүрээлэн (teriologi@mail.ru), О. Климанова, Казахстаны биологийн төрөл зүйлийг хамгаалах нийгэмлэг (olga.klimanova@acbk.kz); Монгол: доктор Б.Лхагвасүрэн & Б. Чимэддорж, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар (lkhagvasuren@wwf.mn; chimeddorj@wwf.mn); ОХУ: Профессор Ю. Арылов, Калмыкын БНУ-ын Зэрлэг амьтан судлах төв (kalmsaigak@elista.ru) & док А. Лушекина, Экологи эволюцийн хүрээлэн (rusmabcom@gmail.com); Узбекистан: Е. Быкова [Executive Editor] & док А. Есипов, Амьтан судлалын хүрээлэн (esipov@xnet.uz); Их Британи: Профессор Е.Ж. Милнер-Гулланд [зөвлөх редактор], Лондонгийн эзэн хааны коллеж (e.j.milner-gulland@imperial.ac.uk).

Бүх өгүүллийг бидний хэрэглэгдэг 6 хэлний аль нэг дээр бичнэ үү. Өгүүллийг esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын аль нэг рүү илгээнэ үү. Бид жилд хоёр удаа гаргадаг. Материалаа esipov@xnet.uz хаягаар эсвэл редакторуудын хэн нэгэнд илгээнэ үү. Сэтгүүл жилд хоёр удаа гардаг. Өгүүлэл бичих журмыг www.saiga-conservation.com хуудсаас эсвэл редакторуудаас англи болон орос хэл дээр авч болно. Хэрвээ танд асуулт гарвал өөрийн улсын Бөхөнгийн мэдээний редактортай эсвэл гүйцэтгэх редактор Елена Быковатай (esipov@xnet.uz) холбогдоно уу.

Энэ дугаарыг онлайн хэлбэрээр www.saiga-conservation.com, <http://saigak.biodiversity.ru/publications.html> болон <http://www.wildlifewarden.net/wcs/mini/saiga-chinese.pdf> сайтуудаас pdf форматаар, эсвэл сэтгүүл хэлбэрээр хүсэлтийн дагуу редакторуудаас англи, казах, хятад, монгол, орос, узбек хэл дээр авч болно.